

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.3, 8.1.5, 8.2, 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нүүр амны тусламж, үйлчилгээнд баримтлах халдварын сэргийлэлт, хяналтын заавар”-ыг нэгдүгээр, “Нүүр амны тусламж, үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын үнэлгээний загвар хуудас”-ыг хоёрдугаар, “Нүүр амны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангахад баримтлах нийтлэг заавар”-ыг гуравдугаар, “Нүүр амны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үнэлгээний загвар хуудас”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Нүүр амны тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, чанар аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж, эмч, мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Э.Анхбаяр), Нүүр ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Б.Баярчимэг), Монголын шүдний мэргэжилтнүүдийн холбоо (Д.Батсайхан)-д зохион байгуулахыг тус тус даалгасугай.

3. Зааврыг мөрдөж ажиллахыг нүүр амны тусламж, үйлчилгээ үзүүлдэг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, зааврыг мөрдүүлэх, хэрэгжилтийг үнэлэх, үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд удирдан зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд чиг үүргийн хүрээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газарт, Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа)-т, Салбарын хяналтын газар (О.Энхболд)-т даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2019 оны 537 дугаар тушаалын тавдугаар хавсралт, 11 дүгээр хавсралтын 3 дугаар хэсгийн 3.3 дахь заалтыг тус тус хүчингүйд тооцсугай.

САЙД

Т. МӨНХСАЙХАН

**НҮҮР АМНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД БАРИМТЛАХ
ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ЗААВАР**

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү зааврыг нүүр амны тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын нүүр амны эмч, сувилагч, туслах ажилтан, лабораторийн техникч, дадлагажигч, оюутан, гэрээт ажилтан бүр өдөр тутмын үйл ажиллагаандаа заавал мөрдөнө.
- 1.2. Нүүр амны тусламж үйлчилгээнд энэхүү заавар болон хүчин төгөлдөр мөрдөж байгаа халдварын сэргийлэлт, хяналт (цаашид“ХСХ” гэх)-ын журам, зааврыг дагаж мөрдөнө.
- 1.3. Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлдэг клиник нь халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагааг өөрийн эмнэлгийн тусламж үйлчилгээний цар хүрээ, онцлог, үйлчлүүлэгчийн тоотой уялдуулан төлөвлөж, хэрэгжүүлнэ.
- 1.4. Хүчин төгөлдөр мөрдөж байгаа ХСХ-ын журамд заасан, тухайн байгууллагад тавих шаардлагын дагуу нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлдэг клиник нь тархвар судлаач эмчийг гэрээгээр, ХСХ-ын асуудлыг хариуцаж, хэрэгжилтийг хангуулж, зөрчил дутагдал, тохиолдлоос сэргийлэх, гарсан тохиолдолд бүртгэх, арилгуулах зэрэг үүрэг бүхий халдварын сэргийлэлт хяналтын эмч эсвэл сувилагчийг удирдлагын шийдвэрээр томилон ажиллуулна.
- 1.5. Эмнэлгийн байр нь эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй байдлыг хангасан, халуун, хүйтэн усанд холбогдсон, хана, тааз, шал нь угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэх боломжтой гөлгөр гадаргуутай, гэрэлтүүлэг, агааржуулалт нь эрүүл ахуйн шаардлага хангасан байна.
- 1.6. Эмнэлзүйн бүсэд багаж, эм, материал болон бусад хэрэгслийг тогтмол байршуулах, ил задгай хадгалах, амьд болон хиймэл цэцэг, чимэглэл, хивс, дрож гэх мэт тоос, шороо цуглуулах зүйл тавихгүй.
- 1.7. Үзлэгийн ор хоорондын зай 2 метрээс доошгүй байна.
- 1.8. Нэг эмч нэг сувилагч эсвэл нүүр амны туслахтай ажиллана.
- 1.9. Мөнгөн усны хольцтой /амальгам/ ломбо хэрэглэхийг хориглоно.
- 1.10. Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа журам, зааврын дагуу эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх чиглэлээр арга хэмжээг хэрэгжүүлж, эрүүл мэндийн ажилтнуудыг халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр тасралтгүй сургах дадлагажуулах ажлыг зохион байгуулна.

Хоёр. Стандарт сэргийлэлт

Стандарт сэргийлэлтийн арга хэмжээнд гарын эрүүл ахуй сахих, хувийн хамгаалах хувцас хэрэгслийг зөв хэрэглэх, тарилгын аюулгүй байдал, эмнэлгийн багаж, хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал, орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, угаалгын үйлчилгээ, хог хаягдлын менежментийн үйл ажиллагааг хамруулна.

2.1. Гарын эрүүл ахуй

2.1.1. Нүүр амны тусламж үйлчилгээ (оношилгоо, эмчилгээ), нүүр амны мэс ажилбарын үед хүчин төгөлдөр мөрдөж байгаа гарын эрүүл ахуй сахих зааврыг баримтална.

2.1.2. Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчийн гар угаах нөхцөлийг бүрдүүлсэн, гар угаах халуун, хүйтэн ус бүхий угаалтуур, шингэн саван, гар арчих зориулалтын нэг удаагийн цаасан алчуур, гар халдваргүйжүүлэх бодисоор хангасан байна.

2.1.3. Нүүр амны тусламж үйлчилгээний эмнэлзүйн өрөөний гарын угаалтуур нь хөл тохойгоор ажилладаг эсвэл мэдрэгчтэй байх ба ажилбарын цэг, цэвэр хэсгээс 1 метрээс багагүй зайд байна.

2.1.4. Эрүүл мэндийн байгууллага нь гар угаах, халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байдал, гар халдваргүйжүүлэх бодисын хэрэглээг жилд хоёроос доошгүй удаа үнэлнэ. Эрүүл мэндийн ажилтан бүрийг гарын эрүүл ахуй сахилтын ажиглалтын үнэлгээнд жилд 1-ээс доошгүй удаа хамруулна.

2.1.5. Нүүр амны мэс заслын тусламж үйлчилгээний үед мэс заслын өмнөх гар угаах, халдваргүйжүүлэх зааварчилгааг баримтална.

2.1.6. Мэс засал, мэс ажилбарт оролцдог эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүрийг мэс засал, мэс ажилбарын үеийн гар угаалтыг маягт дагуу жилд 2-оос доошгүй удаа үнэлнэ.

2.2. Мэс заслын өмнөх гар угаах, халдваргүйжүүлэх зааварчилгаа

2.2.1. Мэс заслын багийн эмч, эмнэлгийн мэргэжилтний гар шархлаагүй, арьсны бүрэн бүтэн байдал алдагдаагүй, гарын хумс хурууны үзүүрээс илүү гараагүй, хиймэл хумс, хумсны будаггүй байна. Бөгж, бугуйвч, бугуйн цаггүй байна.

2.2.2. Хамгаалах хувцас, хэрэгсэл өмссөн байна. Үүнд: маск (ам, хамар далдалсан), малгай (үс, чих далдалсан), нүүрний хаалт (шаардлагатай тохиолдолд), мэс заслын өмд, цамц (цамцны ханцуй тохойноос дээш 15-20 см)

2.2.3. Нэг удаагийн хэрэглээний губка ашиглан гар угаах

2.2.3.1. Губканы уутыг задалж, угаалтуурын дээр гар хялбар хүрэх газар байрлуулна.

2.2.3.2. Гар угаах усны хэм, урсгалыг тохируулан гараа норгосны дараа губканы хатуу үстэй хэсгээр нь зүүн гарын хумсыг 30 удаа үрнэ. Дараа нь баруун гарын хумсыг 30 удаа сайтар үрж угаана.

2.2.3.3. Баруун гарыг бүхэлд нь угаана. Үүнд:

2.2.3.3.1. Гарын ар талыг угаахдаа эрхий хурууг бусад хуруутай нийлүүлсэн байрлалаар 10 удаа үрж угаана.

- 2.2.3.3.2. Гарын алгыг угаахдаа эрхий хурууг бусад хуруутай нийлүүлсэн байрлалаар 10 удаа үрж угаана.
- 2.2.3.3.3. Эрхий хурууны гадна талыг бугуйнаас эхлэн хурууны үзүүр хүртэл 10 удаа үрж угаана.
- 2.2.3.3.4. Эрхий хурууны дотор тал, 4 хурууны завсар хооронд тус бүр 10 удаа үрж угаана.
- 2.2.3.3.5. Баруун гарын бугуйнаас эхлэн тохойноос дээших 5 см хүртэлх зайг хамруулан шууны урд, ард, 2 хажуу тус бүрийг 10 удаа үрж угаана.
- 2.2.3.3.6. Дээрх үйлдэл тус бүрийг губканы зөөлөн хэсгээр давтан гүйцэтгэнэ.
- 2.2.3.4. Зүүн гарыг бүхэлд нь угаана. Үүнд:
 - 2.2.3.4.1. Гарын ар талыг угаахдаа эрхий хурууг бусад хуруутай нийлүүлсэн байрлалаар 10 удаа үрж угаана.
 - 2.2.3.4.2. Гарын алгыг угаахдаа эрхий хурууг бусад хуруутай нийлүүлсэн байрлалаар 10 удаа үрж угаана.
 - 2.2.3.4.3. Эрхий хурууны гадна талыг бугуйнаас эхлэн хурууны үзүүр хүртэл 10 удаа үрж угаана.
 - 2.2.3.4.4. Эрхий хурууны дотор тал, 4 хурууны завсар хооронд тус бүр 10 удаа үрж угаана.
 - 2.2.3.4.5. Баруун гарын бугуйнаас эхлэн тохойноос дээших 5 см хүртэлх зайг хамруулан шууны урд, ард, 2 хажуу тус бүрийг 10 удаа үрж угаана.
 - 2.2.3.4.6. Дээрх үйлдэл тус бүрийг губканы зөөлөн хэсгээр давтан гүйцэтгэнэ.
- 2.2.3.5. Губкыг ямар нэгэн зүйлд хүргэлгүй хаяна.
- 2.2.3.6. Баруун гарыг хурууны үзүүрээс эхлэн тохой хүртэл нэг чиглэлд, урсгал усанд зайлна.
- 2.2.3.7. Зүүн гарыг хурууны үзүүрээс эхлэн тохой хүртэл нэг чиглэлд, урсгал усанд зайлна.
- 2.2.3.8. Гарыг тохойноос дээш түвшинд өргөж, үлдэгдэл усыг угаалтуур руу тохойгоор урсгана.
- 2.2.3.9. Хагалгааны өрөөний хаалгаар нуруугаа харуулан орж, гараа ариун алчуураар хатаана.
- 2.2.4. Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх (ССГХ) бодисоор гар угаах
 - 2.2.4.1. Гарыг ус саван ашиглан энгийн аргаар гараа угаасны дараа ССГХ бодис ашиглан гар угаана.
 - 2.2.4.2. Гар угаах спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх (ССГХ) бодисоо гар оролцуулалгүй (хөл, тохойгоор) авах саванд байршуулна.
 - 2.2.4.3. Баруун гарыг бүхэлд нь угаана. Үүнд:

- 2.2.4.3.1. ССГХ бодисоос зүүн гарын алганд 3 даралт буюу ойролцоогоор 5 мл, гарын алгыг дүүргэж авна. Бодисын саванд гарыг хүргэхгүй.
- 2.2.4.3.2. Баруун гарын хурууны үзүүр, хумсыг зүүн гарын алгахь ССГХ бодист дүрж, 5 секундийн турш үрнэ.
- 2.2.4.3.3. Баруун гарын шуугаар дээшлүүлэн, тохойноос дээш 5 см хүртэлх гарын бүх гадаргууг тойрог, эргэлдүүлэх хөдөлгөөнөөр үрж, угаана.
- 2.2.4.3.4. Үрж угаасан гарын хэсэг рүү буцах үйлдэл хийхгүй.

2.2.4.4. Зүүн гарыг бүхэлд нь угаана. Үүнд:

- 2.2.4.3.5. ССГХ бодисоос баруун гарын алганд 3 даралт буюу ойролцоогоор 5 мл, гарын алгыг дүүргэж авна. Бодисын саванд гарыг хүргэхгүй.
- 2.2.4.3.6. Зүүн гарын хурууны үзүүр, хумсыг зүүн гарын алгахь ССГХ бодист дүрж, 5 секундийн турш үрнэ.
- 2.2.4.3.7. Зүүн гарын шуугаар дээшлүүлэн, тохойноос дээш 5 см хүртэлх гарын бүх гадаргууг тойрог, эргэлдүүлэх хөдөлгөөнөөр үрж, угаана.
- 2.2.4.3.8. Үрж угаасан гарын хэсэг рүү буцах үйлдэл хийхгүй.

2.3. Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл

2.3.1. Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлэх явцад эмнэлгийн мэргэжилтэн халдварт өртөх эрсдэлээс сэргийлж хамгаалах хувцас хэрэгслийг хэрэглэнэ. Хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөц, цэвэр ажлын хувцас, халад зэргийг цэвэр бүсэд битүү шүүгээнд хадгална.

2.3.2. Ажилбарын явцад үйлчлүүлэгчийн цус, шүлс, усны дусал зэргээс үүсэх аэрозолоор дамжин халдварт өртөх эрсдэлээс сэргийлж, ажлын хувцасны гадуур урт ханцуйтай, босоо захтай даавуун материалаар хийсэн ажлын халад эсвэл нэг удаагийн халадыг өмсөнө. Үсийг бүрэн далдалсан малгай, амны хаалт, хамгаалалтын нүдний шил эсвэл нүүрний хаалтыг зүүж, урдуураа битүү ажлын гутал өмсөнө.

2.3.3. Нүүр амны тусламж үйлчилгээний үед нэг удаагийн үзлэгийн бээлийг хэрэглэнэ. Удаан үргэлжлэх ажилбарын үед бээлийг 30 минут тутамд солино.

2.3.4. Мэс засал, мэс ажилбарын үед ариун бээлий хэрэглэнэ.

2.3.5. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь эмчилгээний үед цус, шүлс цацагдахаас сэргийлж хамар, ам, эрүүг бүрэн халхалсан амны хаалтыг хэрэглэнэ. Нэг үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлсний дараа болон үйлчилгээ үзүүлэх явцад бохирлогдсон, норсон тохиолдолд солино.

2.3.6. Дахин ашиглах зориулалттай хамгаалалтын нүдний шил, нүүрний хаалтыг үйлчлүүлэгч бүрийн дараа үйлдвэрлэгчийн зааврын дагуу цэвэрлэнэ.

2.3.7. Рентген зураг авах, бохирлогдсон PSP-ийн хальс барих үед үзлэгийн бээлий, бусад хамгаалах хэрэгслийг өмсөнө.

2.3.8. Латексийн хэт мэдрэгшилтэй ажилтан винил эсвэл нитрил бээлийг хэрэглэнэ.

2.3.9. Бээлийг давхарлаж өмсөхийг хориглоно.

2.3.10. Багаж хэрэгсэл, орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх, хог хаягдалтай харьцах үед ахуйн бээлий өмсөнө.

2.3.11. Нүүр амны эмчилгээний явцад шүдний хагархай, эмтэрхий, буйлны чулуу үсрэхээс хамгаалж, үйлчлүүлэгчид нүдний шил эсвэл нүүрний хэсгийг хамгаалах цонхтой даавуу хэрэглэнэ.

2.4. Тарилгын аюулгүй байдал

2.4.1. Тарилгын үед халдварын эрсдэлээс сэргийлж эмч, эмнэлгийн мэргэжилтэн гарын эрүүл ахуй сахих, үжилгүйжүүлэх дэглэмийг баримтлан үйлдлийн стандартыг мөрдөж ажиллана.

2.4.2. Ажилбар гүйцэтгэхээс өмнө эмийн бодисын бохирдол, тунадас үүссэн эсэх, зүү тариурын битүүмжлэл, хүчинтэй хугацааг шалгана.

2.4.3. Нэг удаагийн зүү, тариурыг нэг хүнд, нэг удаа хэрэглэнэ. Хэрэглэсэн зүү, тариурыг давтан хэрэглэх, тариа найруулахад ашиглахыг хориглоно.

2.4.4. Давтан хэрэглэх зориулалттай хэсгийн мэдээгүйжүүлэлтийн төмөр тариурыг үйлчлүүлэгч бүрд хэрэглэсний дараа зориулалтын сойзоор угааж цэвэрлэн, халдваргүйжүүлж, ариутгана.

2.4.5. Тарианы туншлыг нээхийн өмнө задлах хэсгийг, мөн тарилгын уусмалыг найруулж бэлтгэхдээ зүү хатгах хэсгийг халдваргүйжүүлнэ.

2.4.6. Нүүр амны тусламж үйлчилгээний хэсгийн мэдээгүйжүүлэгчийг нэг удаа хэрэглэх зориулалтын савлагаатай тарилгын уусмалыг хэрэглэнэ. Тарилгын уусмал үлдсэн тохиолдолд шууд устгана.

2.4.7. Тарилгын уусмалыг аль болох бага савлагаатай буюу нэг хүнд, нэг удаа хэрэглэх байдлаар сонгож хэрэглэнэ. Олон туншилтай тарилгын уусмалыг задалсны дараа хадгалж хэрэглэхгүй.

2.5. Хог хаягдлын менежмент

2.5.1. Нүүр амны тусламж үйлчилгээний явцад гарсан аюултай хог хаягдлыг ангилан цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг хүчин төгөлдөр мөрдөж байгаа журам, зааврын дагуу гүйцэтгэнэ.

Гурав. Нэмэлт сэргийлэлт

Нэмэлт сэргийлэлтийн арга хэмжээнд дамжих замд суурилсан, хавьтал, дусал, агаарын жижиг дуслаар халдвар дамжихаас сэргийлэх арга хэмжээг хамруулна. ЭТҮХХ, эмэнд тэсвэржсэн бичил биетний халдвар, халдварт өвчин, халдварын дэгдэлтийн үед стандарт сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна дамжих замд суурилсан сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

3.1. Хавьтлын замаар дамжих халдвартай үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэхдээ нэг удаагийн халад, бээлий өмсөнө. Гарын эрүүл ахуйг чанд сахина.

3.2. Дуслын замаар дамжих халдвартай үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ нэг удаагийн халад, амны хаалт, бээлий, нүдний шил эсвэл нүүрний хаалт хэрэглэнэ.

3.3. Идэвхтэй хэлбэрийн уушгины сүрьеэ, салхинцэцэг, улаанбурхан зэрэг агаарын жижиг дуслуар дамжих халдвартай үйлчлүүлэгчид нүүр амны тусламж үйлчилгээг үзүүлэхдээ тухайн өвчний халдвартай үеийг дуусах хүртэл хугацаанд түр хойшлуулж болно.

3.4. Агаарын жижиг дуслуар дамжих халдвартай үйлчлүүлэгчийг сөрөг даралттай, HEPA шүүлтүүртэй өрөөнд тусгаарлан, тусламж үйлчилгээ үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтэн шүүлтүүртэй амны хаалт (N95, N99, N100 эсвэл FFP2/FFP3), нэг удаагийн халад, бээлий, нүдний шил эсвэл нүүрний хаалт өмссөн байна.

3.5. Халдварын эрсдэлийг бууруулах зорилгоор өвчтөнийг тухайн өдрийн сүүлийн үйлчлүүлэгчээр тооцож тусламж үйлчилгээг үзүүлнэ.

3.6. Улаанбурхан, салхинцэцэгийн халдвартай үйлчлүүлэгчид тухайн халдварын эсрэг дархлаатай эмч, мэргэжилтэн тусламж үйлчилгээ үзүүлнэ.

3.7. Халдвартай үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэхээс өмнө тохирох хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмсөнө. Тусламж үзүүлж дууссаны дараа хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу тайлж, гарын эрүүл ахуйг сахина. Орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг хийнэ.

3.8. Халдвар тараах эрсдэлийг бууруулах зорилгоор зориулалтын резин хаалт (раббердам)-ыг ашиглана.

Дөрөв. Амьсгалын замын халдварын дэгдэлтийн үед баримтлах халдвараас сэргийлэх арга хэмжээ

4.1. Томуу, томуу төст өвчин, амьсгалын замын халдварын дэгдэлтийн үед үйлчлүүлэгч, асран хамгаалагчдад ханиаж найтаахдаа цаасан салфеткаар эсвэл гарын тохойг нугалж ам хамрыг хаах, хэрэглэсэн цаасан салфетикийг хогийн саванд хаях, гарын ариун цэвэр сахих, бусад үйлчлүүлэгчдээс 1 метрээс багагүй зайд суухыг зөвлөж, мөрдүүлнэ.

4.2. Хөтөч ажилтан хүний бөөгнөрөл үүсэхгүй байхаар үзлэгийн цагийг зохицуулалтыг хийнэ. Үйлчлүүлэгчийг амны хаалт зүүхийг зөвлөж, амьсгалын замын халдварын эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн эсэхийг асуумжаар тандана. Халдварын шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгчид нэмэлт сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.3. Хүлээлгийн хэсэгт үйлчлүүлэгчид зориулсан амьсгалын замын халдвараас сэргийлэх санамж, анхааруулга, цаасан алчуур, амны хаалт, гар халдваргүйжүүлэгч, хогийн сав байрлуулна.

4.4. Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлэхийн өмнө үйлчлүүлэгч бүрийн амны хөндийг спирт агуулаагүй, бичил биетний эсрэг үйлчилгээтэй ам зайлах уусмалаар зайлуулна.

Тав. Нүүр амны мэс ажилбар, мэс заслын үеийн халдвараас сэргийлэх арга хэмжээ

5.1. Нүүр амны мэс ажилбар, мэс заслын мэргэшсэн эмч нь дараах мэс засал, ажилбарыг гүйцэтгэнэ:

5.1.1.1. Нүүр амны мэс заслын мэргэшсэн эмч нь дараах мэс ажилбарыг гүйцэтгэнэ:

5.1.1.2. Хүндрэлтэй болон хүндрэлгүй шүд авах

5.1.1.3. Салст зөөлөн эдэд зүслэг хийх

- 5.1.1.4. Буглаа нээх
- 5.1.1.5. Шүдний ёзоор авах
- 5.1.1.6. Хэл уруулын хөвч уртасгах
- 5.1.1.7. Шүлсний булчирхайн чулуу авах
- 5.1.1.8. Сорви, ургацаг, мэнгэ авах
- 5.1.1.9. Шүдний гаралтай ясны үрэвслийн эмчилгээ
- 5.1.1.10. Ортогнатик мэс заслын эмчилгээ
- 5.1.1.11. Шүдний ре-имплантац, трансплантац
- 5.1.1.12. Имплант хийх
- 5.1.1.13. Нүүр амны гэмтлийн эмчилгээ
- 5.1.1.14. Хавдар авах
- 5.1.1.15. Ясыг нөхөх, хусах, нөхөн сэргээх зэрэг хамаарна.
- 5.2. Шүдний тулгуур эдийн мэргэшсэн эмч нь дараах мэс ажилбарыг гүйцэтгэнэ:
 - 5.2.1.1. Шүдний тулгуур эдийн пластик болон нөхөн сэргээх хагалгаанууд (буйл нөхөх, яс нөхөх)
 - 5.2.1.2. Буйл, тулгуур эдийн буглаа нээх
 - 5.2.2. Шүдний сувгийн мэргэшсэн эмч
 - 5.2.2.1. Сурвалжийн орой тайрах
 - 5.2.2.2. Буглаа нээх
 - 5.2.2.3. Шүдний ре-имплантац, трансплантац зэрэг хамаарна.
- 5.3. Нүүр амны мэс заслаар нарийн мэргэшээгүй эмч нь дараах ажилбарыг гүйцэтгэнэ:
 - 5.3.1. Хүндрэлгүй шүд авах
 - 5.3.2. Хэл уруулын хөвч уртасгах
 - 5.3.3. Буглаа нээх
 - 5.3.4. Шүдний гаралтай үрэвсэлт өвчний эмчилгээ
- 5.4. Мэс заслын хэсэг болон мэс ажилбарын өрөө нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, клиник, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт, эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн стандартад заасан шаардлагыг хангасан байна.
- 5.5. Нүүр амны мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага нь мэс заслын хэсэгтэй байна.
- 5.6. Нүүр амны мэс ажилбар (шүд авахаас бусад), шүдний имплантыг шаардлага хангасан ажилбарын өрөөнд хийнэ.
- 5.7. Мэс ажилбарын өрөө нь:
 - 5.7.1. Талбайн хэмжээ төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт 22м²-аас багагүй, клиникт 12м²-аас багагүй байна.

- 5.7.2. Өрөөний шал нь цахилгаанждаггүй материалаар хийгдсэн. Хана нь тосон будаг эсвэл шаазан хавтан, таазыг эмульсээр будсан байна. Шал-хана, тааз-ханын уулзвар ирмэг нь мохоо, хийц материал нь цайвар өнгөтэй, цэвэрлэхэд тохиромжтой, зай завсаргүй байна.
- 5.7.3. Угаалтуур нь хөл, тохойгоор ажилладаг эсвэл мэдрэгчтэй, зэвэрдэггүй ган материалаар хийсэн байна. Тосгуур нь гар угаахад шүргэхээргүй, ус цацагдахааргүй том хэмжээтэй байна. Угаалтуурын ханын хэсгийг ус нэвтэрдэггүй, цэвэрлэхэд тохиромжтой материалаар хийсэн байна.
- 5.7.4. Мэс ажилбарын өрөө нь шүлс соруулагчтай зориулалтын шүдний ор, бусад шаардлагатай тоног төхөөрөмж, багаж, хэрэгслээр хангагдсан байна.
- 5.8. Мэс ажилбарын өрөөнд ажиллах эмч, сувилагч нь зургаан гараар (1 эмч, 2 сувилагч) ажиллана.
- 5.9. Нүүр амны мэс ажилбарын үед мэс заслын үеийн үжилгүйжүүлэх дэглэмийг мөрдөнө. Үүнд:
- 5.9.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтний гарын эрүүл ахуй сахих стандарт сэргийлэлтийг баримтлах.
- 5.9.2. Ариун бээлий, малгай, халад өмсөх, амны хаалт зүүх.
- 5.9.3. Талбайн халдваргүйжүүлэлтийн дэглэм баримтлах.
- 5.9.4. Ариун багаж хэрэгсэл, ариун тусгаарлах даавуу хэрэглэх.
- 5.9.5. Мэс ажилбарт хэрэглэх гэрлийн бариул, өрмийн бариул, соруул, хийн бариул зэрэг тоног төхөөрөмж бүрийн гадаргууг хамгаалалтын наалтаар бүрхэж, халдвараас сэргийлэх зааврыг мөрдөнө.

Зургаа. Орчны халдварын сэргийлэлт, хяналт

6.1. Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартыг хэрэгжүүлнэ.

6.2. Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлдэг клиник нь тухайн байгууллагын тусламж үйлчилгээний чиглэлд тохируулан дараах хэсгүүдийг зохион байгуулна. Үүнд: бүртгэл, хүлээлгийн хэсэг, үзлэг эмчилгээний хэсэг, мэс ажилбарын өрөө, ариутгалын хэсэг, угаалгын хэсэг, урлан, хог хаягдал түр хадгалах цэг, агуулах, ариун цэврийн өрөө, ажилчдын амрах, хувцас солих хэсэг зэрэг байна.

6.3. Нүүр амны үзлэг эмчилгээний хэсгийг эмнэлзүйн бүс болон цэвэр бүсэд хуваана.

6.3.1. Эмнэлзүйн бүс:

- 6.3.1.1. Эмнэлзүйн бүсэд оношилгоо эмчилгээ хийгдэх бөгөөд дараах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг байрлуулна:
- 6.3.1.1.1. Нүүр амны тусламж үйлчилгээний тоноглол бүхий үзлэгийн ор, иж бүрдэл,
- 6.3.1.1.2. Тавцан, өрмийн суурь, соруулын хошууны суурь болон ус хийн шугам хоолойнууд, шүлсний сав, тосгуурын цорго,

- 6.3.1.1.3. Эмч болон сувилагчийн сандал, сандлын товчлуур, гэрлийн бариул,
- 6.3.1.1.4. Рентген зургийн дэлгэц, фото аппарат, дижитал зөөврийн рентген аппарат зэрэг байна.
- 6.3.1.2. Эмнэлзүйн бүсэд эмч, сувилагч, шүдний туслах ажилтан ажиллана. Ажилтан эмнэлзүйн бүсэд тусламж үйлчилгээ үзүүлж байх үедээ цэвэр бүсэд нэвтрэхгүй байхаар ажил үүргийг зохицуулна.
- 6.3.1.3. Ариун материал, эмийн бодис болон бээлий, амны хаалт зэрэг хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг эмнэлзүйн бүсээс гадагш 1.8 метрээс багагүй зайд битүү шүүгээнд хадгална.
- 6.3.1.4. Тоног төхөөрөмжийн солих боломжгүй хүрэлцэх гадаргуу, ус, агаар, соруулагчийн бариул, ломбо, шарах гэрлийн аппаратын хошууг халдваргүйжүүлж, нэг удаагийн хамгаалалтын наалт наана. Үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэхийн өмнө хэрэглэх багаж, хэрэгслийг бэлтгэж, тавиурт байрлуулна.
- 6.3.1.5. Үйлчлүүлэгчид үзлэг эхлэхийн өмнө энгэрэвч, хамгаалах нүдний шилийг зүүлгэж, амны хөндийг халдваргүйжүүлэх уусмалаар зайлуулна.
- 6.3.1.6. Эмчилгээнд хэрэглэгдэх багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ариутгалын хүчинтэй хугацааг үйлчлүүлэгчид танилцуулна.
- 6.3.1.7. Үзлэг, эмчилгээний явцад үүсэх хог хаягдлыг зааврын дагуу ангилж, цуглуулна.
- 6.3.1.8. Эмчилгээний явцад суваг өргөсгөгчийг цэвэрлэхдээ үжлийн эсрэг уусмал шингээсэн ариун материалыг ашиглана.
- 6.3.1.9. Давтан хэрэглэх багаж хэрэгслийг хэрэглэсэн даруйд ариутгалын тасаг / хэсэгт хүргэнэ.
- 6.3.1.10. Орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг хийхдээ цэвэр бүсээс эхэлж, эмнэлзүйн бүс рүү хийнэ.
- 6.3.1.11. Эмнэлзүйн бүсийн цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг бага бохирдолттой хэсгийн гадаргуугаас эхлэн бохирдол ихтэй хэсэг рүү нэг чиглэлээр хийнэ.
- 6.3.1.12. Бохирдол ихтэй хэсэг болох өрөм, хий, усны, чулуу авагчийн хошууны суурь, хоолойн гадаргууг халдваргүйжүүлэх бодистой салфетик эсвэл халдваргүйжүүлэх бодис шингээсэн алчуураар арчина.
- 6.3.1.13. Эмнэлзүйн бүсэд байрлах тоног төхөөрөмжийн хүрэлцэх гадаргууг хамгаалалтын наалт наасан эсэхээс үл хамаарч үзлэг эмчилгээнд хэрэглэсэн тохиолдол бүрийн дараа, өдөр бүр ажлын эхэнд болон төгсгөлд цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг хийнэ.
- 6.3.1.14. Хамгаалалтын наалт, ороогч цаасыг нэг удаа хэрэглэж хаяна.
- 6.3.1.15. Эмнэлзүйн бүсэд тусламж үйлчилгээ үзүүлэх үед хэрэглэсэн даавуун болон нэг удаагийн халаад, амны хаалт, малгай, бээлий зэрэг хамгаалах хувцас хэрэгслийг үзлэг эмчилгээний өрөөнөөс гарахын өмнө тайлна.

6.3.2. Цэвэр бүс:

- 6.3.2.1. Цэвэр бүс нь эмнэлзүйн бүсээс гадагш 1.8 метрээс багагүй зайтай байна.
- 6.3.2.2. Цэвэр бүсэд ариутгасан багаж хэрэгсэл, нэг удаагийн багаж хэрэгсэл, эмийн бодис, эмчилгээний материал, нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгсэл зэргийг битүү шүүгээнд хадгална.
- 6.3.2.3. Багаж, хэрэгслийг шүүгээнд хадгалахдаа баглаа боодлын битүүмжлэлийг алдагдуулахгүй, бохирдуулахгүй байх бөгөөд ариутгалын хүчинтэй хугацаа нь ойрхон, богино байгаа багажийг эхэлж хэрэглэх дарааллаар байршуулна. Хадгалалтын байдал, хугацааг тогтмол хянана.
- 6.3.2.4. Цэвэр бүсэд 2-3 эмчийн дунд сувилагч эсвэл эмчийн туслах ажилтан ажиллана. Цэвэр бүсийн ажилтан эмнэлзүйн бүсэд давхар ажиллахгүй.
- 6.3.2.5. Цэвэр бүсийн сувилагч /туслах ажилтан нь эмнэлзүйн бүсэд ажиллаж байгаа эмч сувилагчид нэмэлтээр шаардлагатай ариун багаж хэрэгсэл, цэвэр материал, эмийн бодис, ломбоны материалыг зааврын дагуу бэлтгэн, дамжуулж өгнө.
- 6.3.2.6. Цэвэр бүсийн сувилагч / туслах ажилтан байхгүй бол цэвэр бүсээс нэмэлт багаж хэрэгсэл, материал авахдаа бээлийг тайлж, гарын ариун цэвэр сахина. Өөрөөр хэлбэл эмнэлзүйн бүсэд хэрэглэж байгаа бээлийтэй гараар цэвэр бүсэд үйлдэл хийхгүй.

6.4. Орчны цэвэрлэгээ халдваргүйжүүлэлт

- 6.4.1. Эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх зааврыг мөрдөнө.
- 6.4.2. Цэвэрлэгээ хийхэд шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл, цэвэрлэгээний багаж хэрэгсэл, материалаар хангасан байна. Цэвэрлэгээнд ашигласан хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх, хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 6.4.3. Цэвэрлэгээнд хэрэглэх багаж хэрэгсэл, материал нь бохирлогдоогүй, цэвэр байх бөгөөд хэрэглэсний дараа халдваргүйжүүлж, угаалгын нунтаг бүхий уусмалаар угааж, цэвэр усанд зайлж, хатаасан байна.
- 6.4.4. Орчны гадаргууг арчиж цэвэрлэхдээ тоос, бичил биетэн агаарт цацагдахаас сэргийлж, чийгтэй цэвэрлэгээ хийнэ.
- 6.4.5. Орчны гадаргууг эмчилгээний үед хүрэлцэх гадаргуу, туслах гадаргуу гэж ангилан, цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг хийнэ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Орчны гадаргуугийн ангилал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх

Гадаргуу	Хамаарагдах хэсэг, багаж тоног төхөөрөмж	Бохирдох байдал	Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх
----------	--	-----------------	------------------------------------

Эмчилгээний үед хүрэлцэх гадаргуу	Эмнэлгийн ажилтны гар шууд хүрэлцэх гадаргуу, тусламж, үйлчилгээний хэсэг	- гэрлийн гар - унтраалга - зураг авах багаж хэрэгсэл - суудлын дэлгэц бүхий товчлуур, хяналтууд - үзлэгийн орны тавцан - өрмийн суурь - шүдний материал - сугардаг ширээний бариул - усны хаалтны бариул	Эмчилгээний үед хүрэлцэх гадаргуу нь цус, шүлс, биеийн шингэн эсвэл биеийн шингэний агууламжтай ус цацагдан бохирдсон гадаргуу эсвэл эмнэлгийн ажилтан бээлийтэй гараар хүрэлцсэн гадаргуу	Эмчилгээний үед хүрэлцсэн бүх гадаргууг үйлчлүүлэгч хооронд, тухайн өдрийн ажлын төгсгөлд цэвэрлэж халдваргүйжүүлнэ.
	Туслах гадаргуу	- шал - хана - цонх - хөшиг - угаалтуур - хаалга - шүүгээ	Эмнэлгийн ажилтны гар хүрэлцэх, бохирлогдсон шингэн асгарах, цацагдах үед бохирлогдоно.	Гадаргууг орчны цэвэрлэгээний зааврын дагуу цэвэрлэж халдваргүйжүүлнэ. Биологийн шингэнээр бохирлогдсон тохиолдол бүрд шууд цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

Долоо. Тусламж үйлчилгээний усны систем

- 7.1. Нүүр амны тусламж үйлчилгээний үед усны хоолойгоор ирэх ус болон амны хөндийгөөс соруулсан шингэний урсгал, хөдөлгөөн тогтмол биш байдаг. Энэ нь усны шугам, сорох системд бичил биетэн үржих, биофильм үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг учраас тогтмол цэвэрлэж, халдваргүйжүүлэх шаардлагатай.
- 7.2. Шүдний өрмийн төхөөрөмж, хэт авиан цэвэрлэгч, нүүр амны эмчилгээ, ам зайлахад хэрэглэгдэх ус нь шүүсэн ус байх ба ундны усны нян судлалын үзүүлэлтийн шаардлагыг хангасан байна.
- 7.3. Ус хангамжийн нэгдсэн системээр ирж байгаа шүүгээгүй ус (крантны ус), ус халаагчийн усыг тусламж үйлчилгээ, үзлэгийн орны тоног төхөөрөмжид хэрэглэхгүй.
- 7.4. Мэс засал, мэс ажилбарт ариутгасан усыг хэрэглэнэ.
- 7.5. Үзлэгийн орны усны системд шүүлтүүр хэрэглэж байгаа бол үйлдвэрлэгчийн зааврын дагуу хугацаанд нь тогтмол сольж, баримтжуулна.
- 7.6. Усны шугам хоолойг цэвэрлэх, халдваргүйжүүлэх:
 - 7.6.1. Өдрийн ажил эхлэхийн өмнө үзлэг орны усны шугам хоолойгоор 2 минутын турш ус, хийг гүйлгэж, үзлэгт бэлтгэнэ.
 - 7.6.2. Үзлэг бүрийн дараа ус, хийн шугам хоолойд угсарч хэрэглэсэн бүх багаж хэрэгслийг 15-20 секундйн турш усаар гүйлгэж, цэвэрлэсний дараа багаж хэрэгслийг салгана.
 - 7.6.3. Өдрийн үзлэг эмчилгээ дууссаны дараа үзлэгийн орны усны шугам хоолойн ус нөөцлөх савыг авч суллана. Тус саванд зориулалтын

халдваргүйжүүлэх уусмалыг хийн угсарч, бодисын үйлдвэрлэгчийн зааврыг баримтлан шугам хоолойг халдваргүйжүүлсний дараа усны савыг суллаж, цэвэрлэж хатаана.

- 7.6.4. Үзлэгийн орны сорох системд халдваргүйжүүлэх бодисыг соруулж, бодисын үйлдвэрлэгчийн зааврын баримтлан халдваргүйжүүлнэ. Бодисыг хэрэглэх, найруулах арга, үйлчлэх хугацаа, аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдөнө.
- 7.7. Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага нь усны нэгдсэн системийн усанд жилд нэг удаа химийн болон нян судлалын шинжилгээг, үзлэгийн орны усны системийн усанд улирал тутамд нян судлалын шинжилгээг хийлгэж, баримтжуулна.
- 7.8. Устай холбоотой халдварын тохиолдол бүртгэгдсэн үед халдварын сэргийлэлт, хяналтын алба, баг, эмнэлгийн удирдлагад мэдээлж, усны системд шинжилгээ, тандалт судалгааг хийж хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.

Найм. Нүүр амны тусламж, үйлчилгээнд давтан ашигладаг багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал

- 8.1. Багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгахад хүчин төгөлдөр мөрдөж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах зааврыг баримтална.
- 8.2. Тусламж үйлчилгээний цар хүрээ, өмчийн хэлбэрээс үл хамааран шүдний эмнэлэг нь тусламж үйлчилгээнд хэрэглэдэг багаж, хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах заавар, журамтай байна.
- 8.3. Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага нь дотроо ариутгалын тасаг эсвэл хэсэгтэй, ариутгалын хэсэг нь 8м²-аас доошгүй талбайтай, нэг чигийн урсгалтай байна.
- 8.4. Ариутгалын тасаг/хэсгийг бохир, цэвэр бүстэй, бүсүүдийг ханаар тусгаарлаж, дундаа цонхтой байхаар зохион байгуулна. Бохир хэсэгт багаж хэрэгслийг хүлээн авч, угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэх хатаах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Цэвэр хэсэгт багаж хэрэгслийн арчилгаа савлагаа, ариутгалыг гүйцэтгэнэ. Төвлөрсөн ариутгалын тасагтай бол ариун материал хадгалах өрөөтэй байна. Ариутгалын хэсэгтэй бол ариутгасан багаж, хэрэгслийг тусламж үйлчилгээний цэвэр бүсэд хадгална.
- 8.5. Ариутгалын тасаг/хэсэгт өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон халдваргүйжүүлэлт, ариутгалын тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн заавар, мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлд үндэслэн, хяналттайгаар суурилуулж ажиллуулна.
- 8.6. Багаж хэрэгслийн цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах үйл ажиллагааг мэргэжил олгох сургалтад хамрагдсан ажилтан гүйцэтгэнэ.
- 8.7. Цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах үйлдвэрлэгчийн тусгайлсан зөвлөмж, зааварчилгаа бүхий давтан ашигладаг багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалыг хийхдээ үйлдвэрлэгчийн зааврыг мөрдөнө.

8.8. Үйлдвэрлэгчийн зааварт нэг удаа ашиглах зориулалттай гэж тодорхойлсон багаж, хэрэгсэл, төхөөрөмжийг зөвхөн нэг удаа хэрэглэнэ. Үүнд:

- Нэг удаагийн зүү, тариур
- Хутганы ир
- Оёдлын утас
- Багс
- Зөөлц авагч
- Сувгийн хар зүү
- Бреккет
- Бөгж
- Нум
- Тюба
- Легатурын утас
- Резин (өнгийн, холбогч, татлагын, зай гаргагч)
- Урьдчилан сэргийлэх үзлэгийн багц
- Цаасан энгэрэвч
- Гадаргуугийн наалт
- Бээлий
- Шүлс сорогчийн нарийн хуванцар хошуу
- Ус агаар шүршигчийн хуванцар хошуу гэх мэт

8.9. Нүүр амны тусламж үйлчилгээнд хэрэглэдэг багаж хэрэгслийг халдварын эрсдэлийн түвшингээр нь өндөр, дунд, бага эрсдэлтэй гэж ангилж, тохирох аргаар цэвэрлэж, халдваргүйжүүлж, ариутгана (Хүснэгт 2).

Хүснэгт 2. НАТУ-ий багаж хэрэгсэл, халдварын эрсдэлийн түвшингээр

Эрсдэл	Хэрэглэгдэх байдал	Хамаарах багаж, хэрэгслүүд	Ариутгах, халдваргүйжүүлэх аргууд
Өндөр эрсдэлтэй	Яс, зөөлөн эд, цусны урсгалд нэвтэрдэг багажууд	• Хэсгийн мэдээгүйжүүлэлтийн тариур (төмөр шприц) • Сувгийн багажууд (гар болон машины файл, ример) • Мэс заслын самбай • Шүдний имплантын багажууд • Төмөр матриц (хэрэглэхийн өмнө) • Амны толь (эдийг зүсэж гэмтээсэн ажилбарын үед ашигласан) • Гажиг заслын банд (хэрэглэхийн өмнө) • Тулгуур эдийн багажууд (ультрасоникийн хошуу) • Нүүр амны эмчилгээнд хэрэглэгддэг багажууд • Өрмийн толгой болон алмазан бор • Раббер дамын бөгжнүүд • Чулуу авагчууд • Зэвэрдэггүй ган бүрээсүүд (хэрэглэхийн өмнө) • Мэс заслын багажууд • Мэс заслын шүлс сорогчийн хошуу	Даралтат уураар болон хуурай халуунаар ариутгана.

Дунд эрсдэлтэй	Гэмтсэн арьс, салст бүрхэвчинд хүрэх	• Хазалтын цаас баригч • Агаар хийн хошуу • Өрмийн бариул • Цөгц доргиогч • Раббер дамын хүрээ болон бахь • Хэвний халбага • Шүдний лабораторийн бор • Хамрын маск • Гажиг заслын бахь • Голлосон хоршихуй тодорхойлогч • Лабораторийн хутга, шпатель	Хуурай халуунаар ариутгана. Халуунд мэдрэг багаж хэрэгслийн өндөр түвшний халдваргүйтгэл Нэг удаагаар хэрэглэнэ.
Бага эрсдэлтэй	Гэмтээгүй арьс, салстад хүрэх	• Даралтын аппарат • Гэрлийн аппарат • Рентген хормогч • Амны камер болон рентген сенсор • Раббер дамын цоологч • Лабораторийн тусгай багажууд	Дунд түвшний халдваргүйтгэгч бодисоор халдваргүйжүүлнэ.

8.9.1. Багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах

8.9.1.1. Багаж хэрэгслийг цэвэрлэх

8.9.1.1.1. Багаж хэрэгслийг халдваргүйжүүлэлт, ариутгал хийхээс өмнө органик бохирдлыг арилгах энзим (фермент) болон угаагч бодис (детергент)-ын найрлагатай зориулалтын бодисоор угааж, цэвэрлэнэ.

8.9.1.1.2. Багажийг гараар цэвэрлэхээс гадна хэт авианы цэвэрлэгч, угаагч машин зэрэг автомат цэвэрлэгээний төхөөрөмжийг ашиглаж болно.

8.9.1.1.3. Угааж, халдваргүйжүүлэгч автомат машиныг үйлдвэрлэгчийн зааврын дагуу ажиллуулна. Зориулалтын бодис ашиглана.

8.9.1.1.4. Хэт авианы цэвэрлэгчийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу ажиллуулж, цэвэрлэгээний уусмалыг өдөр бүр эсвэл илт бохирдсон тохиолдолд солино.

8.9.1.1.5. Зориулалтын угааж халдваргүйжүүлэх машин байхгүй үед гараар цэвэрлэнэ. Цэвэрлэгээ хийх хэсэг нь эмнэлзүйн бүсээс зайтай, тусгаарлагдсан байна.

8.9.1.1.6. Цэвэрлэсэн багажийг тулд шүүсэн эсвэл зөөлрүүлсэн бүлээн усаар сайтар зайлж цэвэрлэгч бодисын үлдэгдлийг арилгана.

8.9.1.1.7. Цэвэрлэгээ хийх ажилтан зориулалтын бээлий, хамгаалалтын нүдний шил, нүүрний маск, ус нэвтрэхгүй хормогч, ханцуйвч зэрэг хамгаалалтын хувцас өмсөнө.

8.9.1.2. Цэвэрлэгээний чанарыг шалгах

8.9.1.2.1. Багажийн гадаргуу, ховил нүх зэрэг эрсдэлтэй хэсэгт гэрэлтдэг томруулдаг линзийн тусламжтайгаар өдөр бүр шалгана.

8.9.1.2.2. Цус, уургийн үлдэгдэл, цэвэрлэгээний чанар, төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг зориулалтын сорил (Foil-test, SonoCheck, TOSI, HemoCheck, Pyromol-Test гэх мэт) ашиглан, үйлдвэрлэгчийн зааврыг баримтлан, сард 1-ээс доошгүй удаа хянана.

8.9.1.2.3. Foil-test сорил хийх: савны урт болон гүний хэмжээтэй ижил хэмжээтэй мөнгөлөг цаасыг төхөөрөмжид байгаа уусмалд савны ёроолд хүрэхгүй байхаар дүрж, 30 секунд турш дээд хэмжээгээр ажиллуулна. Мөнгөлөг цаас 1-4 мм диаметр хэмжээтэй цоорч, нүх үүсвэл төхөөрөмж хэвийн ажиллагаатай байна гэж үзэх бөгөөд сорил хийсэн огноо, хугацааг тэмдэглэж, хадгална. Сорилд ашигласан уусмалыг багажийн цэвэрлэгээнд хэрэглэхгүй.

8.9.1.3. Багаж хэрэгслийг халдваргүйжүүлэх, ариутгах

8.9.1.3.1. Давтан хэрэглэдэг багаж хэрэгслийг угааж, халдваргүйжүүлэхдээ зориулалтын автомат машин ашиглаагүй, хэт авианы цэвэрлэгчээр эсвэл гараар угааж цэвэрлэсэн бол химийн бодис ашиглан халдваргүйжүүлнэ. Халдваргүйжүүлсний дараа ариутгана.

8.9.1.3.2. Багаж, хэрэгслийн онцлог, халдварын эрсдэлийн зэргийг харгалзан тохирох ариутгалын аргаар ариутгана.

8.9.1.3.3. Өндөр эрсдэлтэй, халуунд мэдрэг багаж хэрэгслийг цэвэрлэж, халдваргүйжүүлсний дараа устөрөгчийн хэт ислийн хийн плазм эсвэл химийн аргаар ариутгана. Өндөр эрсдэлтэй, халуунд тэсвэртэй багаж хэрэгслийг цэвэрлэж, халдваргүйжүүлсний дараа даралтат халуун уурын эсвэл хуурай халууны аргаар ариутгана.

8.9.1.3.4. Дунд эрсдэлтэй багаж хэрэгслийг цэвэрлэж, халдваргүйжүүлэн, ариутгана. Ариутгах шаардлагагүй болон ариутгах боломжгүй, халуунд мэдрэг багаж хэрэгслийг өндөр түвшний халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйжүүлнэ.

8.9.1.3.5. Бага эрсдэлтэй багаж хэрэгслийг цэвэрлэж, бага эсвэл дунд түвшний халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйжүүлнэ.

8.9.1.3.6. Багаж хэрэгслийн ариутгалын үйл явц бүрэн гүйцэт явагдсан эсэхийг одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа зааврын дагуу хянана.

8.9.1.4. Шүдний өрмийн бариул, бусад туслах багаж, хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал:

8.9.1.4.1. Амны хөндийгөөс шүлс, шингэнийг сордог багаж хэрэгслийг үйлчлүүлэгч бүрийн дараа ус, хийг 20-30 секунд турш зэрэг үлээлгэж, шугам хоолойг цэвэрлэсний дараа холбогч хоолойноос салгаж, үйлдвэрлэгчийн зааврын дагуу цэвэрлэж, халдваргүйжүүлж, тосолж, ариутгана. Үйлчлүүлэгч бүрд ариутгасан багаж хэрэглэнэ. Үүнд:

- хурдан болон удаан эргэлтэт өрмийн бариул
- мэс заслын өрмийн бариул
- шулуун өрмийн бариул
- ультрасоник
- чулуу авагчийн хошуу, бариул
- сувгийн өрмийн бариул
- өнгөлгөөний резинэн бариул

- өнгөлгөөний багаж (агаараар үлээлгэгч),
- агаар, усны хошуу

8.9.1.4.2. Шүлс сорогчийн хошууг үйлчлүүлэгч хооронд 20 секундийн турш усаар соруулж цэвэрлэнэ.

8.9.1.4.3. Үзлэгийн орноос салгах боломжгүй, бэхлэгдсэн моторын гар, ультрасоник багажийн гар, шүлс сорогч, өндөр давтамжит соруул, ус хийн хошууны бариул зэрэг багаж хэрэгслийг үйлчлүүлэгч бүрийн дараа гадаргууг цэвэрлэж, халдваргүйжүүлэн, хамгаалалтын наалт нааж хэрэглэнэ.

8.9.1.4.4. Шүдний хурдан болон удаан эргэлтэт өрмийн бариул, ультрасоник, чулуу авагчийн бариулыг цэвэрлэж, халдваргүйжүүлж, савлаж зориулалтын автоклавт ариутгана.

8.9.1.4.5. Багаж, хэрэгслийн онцлогт тохирсон зориулалтын халдваргүйжүүлэх бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.

Ес. Шүдний урлан, согог гажиг заслын тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт хяналт

9.1. Шүдний урлангийн халдварын сэргийлэлт, хяналт

9.1.1. Шүдний урлан нь агааржуулалтын системтэй, агаар сэлгэлт сайтай байх бөгөөд хүлээн авах, хэвлэх, өнгөлгөөний хэсгүүдтэй байхаар зохион байгуулна. Өнгөлгөөний хэсэг нь засвар шүдэлбэрийн өнгөлгөөний болон шинэ шүдэлбэрийн өнгөлгөөний гэсэн хэсэгтэй, хэсэг тус бүрд сорогч вакум үүсгэгч суурилуулсан байна.

9.1.2. Шүдэлбэр, зэмсэг, хэв, урьдал хийц, шүдэлбэр, голлосон хоршихуй тодорхойлогч, хазалтын төлөв тодорхойлогч зэргийг эмнэлгийн доторх болон гаднах бусад лаборатори руу илгээхийн өмнө тухайн ажилбар/хийц материалын шинж чанарт тохирсон цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хийж, чийгтэй байгаа хэв, зэмсгийг шингэн нэвчихгүй саванд битүүмжлэн тэмдэглэгээг хийж зөөвөрлөнө.

9.1.3. Хүлээн авсан хийц, хэв, загвар, шүдэлбэр бохирдолтой бол цэвэрлэж, халдваргүйжүүлнэ. Материал илгээсэн байгууллагад мэдэгдэж анхааруулна.

9.1.4. Гэрээт байгууллага руу материалыг зөөвөрлөх тохиолдолд холбогдох журмыг баримтална.

9.1.5. Засвар шүдэлбэрийг засварлах тохиолдолд өнгөлөх хэсэгт орохоос өмнө халдваргүйжүүлэх бөгөөд өнгөлгөөний хэрэгслийг хэрэглэсний дараа цэвэрлэж, халдваргүйжүүлнэ. Чулуун өнгөлгөөг халдваргүйжүүлэгч ашиглан чийглэх бөгөөд хэрэглэсний дараа шууд хаяна. Мөн тавцанг угааж халдваргүйжүүлнэ.

9.1.6. Урлангийн ажилтан цэвэрлэгээ халдваргүйжүүлэлт хийх явцад хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөнө.

9.1.7. Орчны гадаргууд хамгаалалтын наалт наах эсвэл цэвэрлэж халдваргүйжүүлнэ.

- 9.1.8. Урлангийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг холбогдох тушаал, зааврын дагуу устгана.
- 9.1.9. Биопсийн сорьцыг холбогдох тушаал, зааврын дагуу хадгалж, тээвэрлэнэ.
- 9.2. Нүүр амны согог, гажиг заслын тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналт
- 9.2.1. Гажиг заслын тусламж үйлчилгээнд давтан хэрэглэгдэх багаж хэрэгслийг халдварын эрсдэл, хэрэглэгдэх байдалд үндэслэн холбогдох ариутгалын зааврын дагуу цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалыг хийж гүйцэтгэнэ.
- 9.2.2. Шүдний урлан руу илгээх ажилбар/хийцийг цэвэрлэж, халдваргүйжүүлж дагалдах тэмдэглэгээг хийж, саванд битүүмжлэн зөөвөрлөнө.
- 9.2.3. Силикон болон полиуретаны төрлийн материалаар авсан хэвэнд наалдсан бохирдлыг зориулалтын цэвэрлэгээний уусмалаар цэвэрлэж, халдваргүйжүүлэн битүү саванд хийж дагалдах тэмдэглэгээг хийж урлан руу илгээнэ.

Арав. Рентген шинжилгээний үеийн халдварын сэргийлэлт хяналт

- 10.1. Рентген шинжилгээний хальс баригч, чиглүүлэгч зэрэг халдварын эрсдэл багатай багаж хэрэгслийг үйлчлүүлэгч хооронд химийн аргаар халдваргүйжүүлнэ.
- 10.2. Рентген туяа өгөгч толгой хэсэг, удирдлагын хэсэг зэрэг гар хүрэх хэсгүүд, бохирлогдсон PSP-гийн болон энгийн хальсыг үйлчлүүлэгч хооронд цэвэрлэж халдваргүйжүүлнэ эсвэл хамгаалалтын наалтыг солино.
- 10.3. Зураг авсны дараа бээлийг тайлахаас өмнө бохирлогдсон PSP-г халдваргүйжүүлж, цэвэр саванд хийж боловсруулах хэсэг руу зөөвөрлөнө.
- 10.4. Бээлийг тайлж, хальсны боловсруулалт хийнэ. Хальс боловсруулах төхөөрөмжийг бохирдуулахаас сэргийлж хамгаалалтын наалт наана. Бохирдсон гадаргууг цэвэрлэж халдваргүйжүүлнэ.
- 10.5. Дижитал рентгений PSP, сенсор болон бусад тоног төхөөрөмж, хэрэгслийг (амны камер, тулгуур эдийн электрон багаж, хоршилтын анализатор, лазер) хэрэглэхийн өмнө хамгаалалтын наалтаар бүрж, дараагийн үйлчлүүлэгчид хэрэглэхээс өмнө үйлдвэрлэгчийн зааврын дагуу халдваргүйжүүлнэ.
- 10.6. Үйлчлүүлэгчийн цус, шүлсээр бохирдсон гадаргууг зааврын дагуу цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.
- 10.7. Туяанаас хамгаалах хормогч, хүзүүвч бохирдсон тохиолдолд дараагийн үйлчлүүлэгчид хэрэглэхээс өмнө цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

Арван нэг. Явуулын нүүр амны тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт хяналт

- 11.1. Алслагдсан газар, орон нутгийн иргэдэд НАТУ-г явуулын хэлбэрээр үзүүлэхдээ халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр баримтлах хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа холбогдох тушаал, журмыг мөрдлөг болгон

ажиллана. Тусламж үйлчилгээг явуулаар үзүүлэх нь эмнэлгийн тусламж үйлчилгээнд баримтлах халдвараас сэргийлэх хянах дэглэмийг бууруулах шалтгаан болохгүй.

- 11.2. Эмнэлгийн зориулалтын тээврийн хэрэгсэлд тусламж үйлчилгээ үзүүлэх бол нүүр амны тусламж үйлчилгээний усны системд тавигдах шаардлагыг хангасан байна. Тусламж үйлчилгээний явцад усны системийн халдварын сэргийлэлт хяналтыг зааврыг чанд баримтална.
- 11.3. Үйлчлүүлэгчийг эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эрсдэлээс сэргийлэх зорилгоор явуулаар үзүүлэх тусламж үйлчилгээний төрөл, үйлчлэх хүрээний хүн амын тоо, эрүүл мэндийн ажилтны ачаалал, тусламж үйлчилгээ үзүүлэх байрны багтаамж, хүчин чадлыг тооцон нэг удаагийн болон давтан хэрэглэдэг тоног төхөөрөмж, багаж, эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгсэл, цэвэрлэгээний материал, халдваргүйжүүлэх бодис зэргийн шаардлагатай нөөцийг хүрэлцэхүйц хэмжээгээр бүрдүүлсэн байна.
- 11.4. НАТУ-ээс гарах энгийн болон аюултай хог хаягдлын холбогдох заавар, журмын дагуу цуглуулна. Орон нутгийн холбогдох байгууллагатай аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах талаар гэрээ байгуулж, хүчин төгөлдөр мөрдөж байгаа журмын дагуу гүйцэтгэнэ.
- 11.5. Явуулын нүүр амны тусламж үйлчилгээний үед давтан хэрэглэгдэх багаж хэрэгслийн халдваргүйжүүлэлт ариутгалыг гүйцэтгэхдээ эмнэлгийн зориулалтын тээврийн хэрэгсэлд ариутгалын үйл ажиллагааг хийх нөхцөлийг бүрдүүлсэн, сургагдсан мэргэжлийн ариутгалын ажилтантай бол явуулын баг өөрсдөө гүйцэтгэнэ. Эсвэл орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын ариутгалын тасаг/хэсэгт гэрээгээр гүйцэтгүүлж болно.
- 11.6. Давтан хэрэглэдэг багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалын чанарын хяналтыг холбогдох зааврын дагуу хэрэгжүүлж, анхан шатны бүртгэлийн маягтыг хөтөлж, баримтжуулна.
- 11.7. Урьдчилан сэргийлэх үзлэгийг явуулаар үзүүлэхдээ нэг удаа хэрэглэх зориулалттай үзлэгийн багцыг хэрэглэнэ. Хэрэглэсэн нэг удаагийн багаж хэрэгслийг давтан хэрэглэхгүй.
- 11.8. Урьдчилан сэргийлэх үзлэгээс бусад эмчилгээ, тусламж үйлчилгээнд нэг удаагийн үзлэгийн багаж хэрэгслийг хэрэглэхгүй.

Арван хоёр. Нүүр амны тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ

12.1. Нүүр амны тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагаанд хийх үнэлгээ нь “Нүүр амны тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үлгэрчилсэн үнэлгээ”-ний бүрэлдэхүүн хэсэг байж болно.

12.2. Нүүр амны тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагаанд хийх үнэлгээний загвар асуумжийг эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах зорилгоор дотоод хяналт хийхэд ашиглана. Мөн үндэсний болон орон нутгийн халдварын сэргийлэлт хяналтын асуудал хариуцсан байгууллага, салбар зөвлөл, мэргэжлийн холбоо, нийгэмлэгүүд хөндлөнгийн хяналт хийхдээ ашиглаж болно (Хүснэгт 3 ба 4)

Хүснэгт 3.

Нүүр амны тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын үнэлгээний загвар

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээний дүн: 0 - байхгүй 1 - дунд 2 - сайн
1.	Байгууллага нь халдварын сэргийлэлт, хяналтын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана.	1.1. Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон халдварын сэргийлэлт, хяналт /ХСХ/-ын төлөвлөгөөтэй байх	1. Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон ХСХ-ын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, баталсан	
			2. Төлөвлөгөөнд ХСХ-ын асуудлыг тусгасан ○ Байнгын сэргийлэлтийн үйл ажиллагаа ○ Нэмэлт сэргийлэлтийн үйл ажиллагаа ○ ЭМА-ыг сургах ○ ЭТҮХХ-ын тандалт ○ ЭМА-ыг халдвараас сэргийлэх ○ Дотоод хяналт, үнэлгээ хийх	
			3.Төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр дүгнэж, хэрэгжилтийн хувь гаргасан	
		1.2. ХСХ-ын асуудал хариуцсан алба/багтай байх	1.ХСХ-ын орон тооны болон орон тооны бус алба/баг ажилладаг 2. ХСХ-ын алба/баг нь ○ Орон тооны тархвар судлаач ○ ХСХ-ийн эмч ○ ХСХ ажилтан ○ Гэрээт тархвар судлаач	

		1.3. ХСХ-ын чиглэлээр хяналт үнэлгээ хийж, үр дүнг тооцсон	1.ХСХ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөө, хуваарьтай байна.	
			2.Хяналт, үнэлгээнд хяналтын хуудас ашигладаг	
			3. Дотоод хяналт хийж, үр дүнг тооцсон	
			4. Хяналт үнэлгээний үр дүнгээр ХСХ-ын үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн	
		1.7. Эрүүл мэндийн ажилтанд ХСХ-ын мэдлэг олгох сургалт хийдэг байх	1. Сургалтын хөтөлбөрт байнгын болон нэмэлт сэргийлэлт, халдварын илрүүлэлт тандалт, ЭМА-г халдвараас сэргийлэх зэрэг агуулга тусгагдсан байна.	
			2. Шинэ ажилтныг ХСХ чиглэлээр баримжаа олгох сургалтад хамруулдаг	
			3.Сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан	
			4. НАТУ-ний ажилтан бүрийн сургалтад хамрагдсан байдлыг бүртгэж хөтөлдөг.	
Онооны дүн		Авбал зохих оноо		
		Авсан оноо		
2.	ЭМА-ыг халдвараас сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлдэг үйл	2.1.ЭМА-ыг халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан, дархлаажуулалтын нэгдсэн мэдээлэлтэй	1. ЭМА-ыг халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулах дотоод журамтай.	
			2. Шинэ ажилтныг ажилд томилогдохоос өмнө эрүүл мэндийн хуудас/маягтын дагуу халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан, бүртгэл судалгаатай.	
			3. ЭМА-ыг жил бүр халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан /Сүрьеэ, гепатитын В, С, D вирус, ХДХВ, МТСА илрүүлэх шинжилгээ багтсан байх/	
			4. Улаанбурхан, гахай хавдар, улаанууд, гахай хавдар, сахуу, хөхүүл ханиад, татрангийн дархлаажуулалтад хамрагдсан, өвдсөн эсэх судалгаатай	
			2. Халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн тохиолдлыг бүртгэж хариу арга хэмжээ авсан, бүртгэлийн хуудас хөтөлсөн	

			3. Халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн тохиолдолд халдвараас сэргийлэх хариу арга хэмжээ авсан, бүртгэлтэй	
			4. В гепатитын дархлаажуулалтад 48 цагийн дотор, ретровирусын эсрэг эмийг 72 цагийн дотор уух боломжоор хангаж зохицуулалт хийсэн байх	
		2.2.ЭМА-ыг гар угаах нөхцөлөөр хангасан	1. Ажилбар хийгддэг өрөө бүрд гар угаах угаалтууртай	
			2. Угаалтуур нь халуун, хүйтэн устай, цэвэр бохир усны шугамд холбогдсон	
			3. Угаалтуур бүр шингэн савантай	
			4. Нэг удаагийн цаасан алчуур хэрэглэдэг	
			5. Угаалтуур эвдрэл гэмтэлгүй ажилладаг	
			6. Мэс заслын өрөөний гарын угаалтуур нь хөл, тохойгоор ажилладаг эсвэл мэдрэгчтэй, зэвэрдэггүй ган материалаар хийгдсэн, тосгуур нь тохой хүртэл гар угаахад шүргэхээргүй, ус цацагдахааргүй том хэмжээтэй	
			7. Тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа цэгүүдэд шахуурга бүхий гар халдваргүйжүүлэх бодистой	
			8.Гар халдваргүйжүүлэх бодисын спиртын агууламж 70-80 хувьтай	
			9. Гар халдваргүйжүүлэх бодис нь улсын бүртгэлд бүртгэгдсэн	
			10. Гар угаах, халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байдал, гар халдваргүйжүүлэх бодисын хэрэглээ, ажилтны гарын эрүүл ахуй сахилтын мэдлэг, дадалд ажиглалтын үнэлгээг үнэлгээ хийдэг.	
		2.3. ЭМА-ыг халдвар авах эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх арга хэмжээ авдаг байх	1.Хувийн хамгаалах хэрэгсэл (Нэг удаагийн малгай, амны хаалт, бээлий г.м)-ээр тасралтгүй хангадаг, бүртгэлтэй	
			2.ЭМА-ны гарын арьс хуурайших, хагарахаас сэргийлж гар угаах, халдваргүйжүүлэх бүтээгдэхүүн харшил, хуурайшуулах нөлөө үзүүлж байгаа эсэхийг хагас жил тутамд судалсан, бүтээгдэхүүнийг өөрчлөх арга хэмжээ авсан	
			3. Ажилтны ажлын хувцас (халаад, өмд цамц) 2 ээлжээс багагүй байх	
			4. Эмнэлэгт өмсөх урдуураа битүү гутал, углаашаар хангасан	
Онооны дүн		Авбал зохих оноо		

		Авсан оноо					
3.	Үйлчлүүлэгчийг халдвараас сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	3.1. Үйлчлүүлэгчид ээлтэй, тав тухтай эрүүл ахуйн шаардлага хангасан орчинг бүрдүүлсэн байх.	1.Байгууллага нь ус, дулаан, цахилгаан, агааржуулалт, ариун цэврийн байгууламжийн төвлөрсөн болон хэсгийн сүлжээнд холбогдсон.				
			2.Үзлэг, эмчилгээ, хүлээлгийн хэсгүүд нь тусдаа зохион байгуулагдсан, эрүүл ахуйн шаардлага хангасан.				
			3. Үзлэг, оношилгоо, эмчилгээний өрөөний талбайн хэмжээ стандартын шаардлага хангасан.				
			4. Үзлэгийн ор хоорондын зай 1,8 м-ээс багагүй				
			5. Өрөө бүр нь дулаан, гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай, тав тухтай орчин бүрдүүлсэн байна.				
Онооны дүн		Авбал зохих оноо					
		Авсан оноо					
4.	ЭТҮХХ илрүүлэх тандалтыг хийж, дүгнэлт өгч, хариу арга хэмжээ авдаг байна.	4.1.Үйлчлүүлэгчийн дунд ЭТҮХХ илрүүлэх тандалтыг хийж, дүгнэлт өгч, хариу арга хэмжээ авдаг байна.	1. Үйлчлүүлэгчийн дунд ЭТҮХХ илрүүлэх тандалтыг хийсэн бүртгэлтэй				
			2. Мэс ажилбар, мэс заслын дараах халдварын тандалт хийдэг				
			3. Тандалтаар илрүүлсэн халдварын тохиолдлыг бүртгэж, холбогдох байгууллагад мэдээлдэг				
			4. Халдвар гарахад нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг тогтоож эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан				
		4.3. Эмэнд тэсвэртэй бичил биетний халдвар тархахаас сэргийлэх арга хэмжээ авдаг байх	1.Эмэнд тэсвэртэй бичил биетний халдвар илэрсэн үед авах арга хэмжээний заавартай байх				
			2.Эмэнд тэсвэртэй бичил биетний халдвартай үйлчлүүлэгчид нэмэлт сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлдэг байх				
			3. Эмэнд тэсвэртэй бичил биетэн илэрсэн ЭМА, үйлчлүүлэгчид деколонизаци хийдэг, бүртгэлтэй				
			4. Деколонизаци хийсний дараа хяналтын шинжилгээнд хамруулсан байх				
			Онооны дүн		Авбал зохих оноо		

		Авсан оноо		
5.	Ариутгалын тасаг, нэгжийг ажиллуулж цэвэр, ариун аюулгүй байдлыг хангасан багаж, хэрэгслээр тусламж, үйлчилгээ үзүүлнэ.	5.1.Ариутгалын нэгдсэн тасаг/нэгжтэй, зөв зохион байгуулагдсан	1.Зааврын дагуу зохион байгуулсан ариутгалын тасаг, хэсэгтэй	
			2.Бохир, цэвэр, ариун хэсгийг ханаар тусгаарласан нэг чигийн урсгалтай	
			3.Ариун материалыг хадгалах өрөөтэй.	
			4.Цэвэр, бохир усны шугамд холбогдсон.	
			5.Агааржуулалтын нэмэлт систем суурилуулсан.	
			6.Цахилгаан хангамж, гэрэлтүүлэг гэх мэт шаардлагатай дэд бүтцийг бүрдүүлсэн.	
		5.2.Ариутгалын тасаг, нэгж нь шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байх	1.Тоног төхөөрөмж нь хэвийн ажиллагаатай, үйл ажиллагаандаа тохирсон, хүрэлцээтэй	
			2.Бохир багаж хэрэгслийг гараар угаах хэрэгслээр болон зориулалтын угаах машинтай.	
			3. Хатаах шүүгээ эсвэл өрөөний хэмд хатаах тавиур, ширээ, арчиж хатаах даавуун алчуураар хангагдсан	
			4.Өөрийн үйл ажиллагааг хянадаг автомат тохируулга бүхий 1-оос доошгүй автоклавтай	
			6. Багаж хэрэгслийг зориулалтын боолтын материалаар боож, савладаг	
			7. Томруулах шил, хөндийтэй багаж хэрэгслийг сэтгүүрдэж угаах сойз гэх мэт бусад дагалдах хэрэгслээр хангасан	
		5.3. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд улсын бүртгэлд бүртгэгдсэн бодисыг зориулалтын дагуу ашигладаг байх	1.Багаж хэрэгслийн угаалга, цэвэрлэгээ хийх бодис нь органик бохирдол арилгах энзим (фермент) болон угаагч бодис (детергент)-ын найрлагатай	
			2. Улсын бүртгэлтэй цэвэрлэгээ, халдваргүйжүүлэх бодисуудыг ашигладаг	
			3. Бодисыг батлагдсан зааврын дагуу найруулж, хэрэглэдэг	
		5.4.Давтан хэрэглэгдэх багаж	1.Тусламж үйлчилгээний чиглэл тус бүрээр давтан ашиглах багаж хэрэгсэл, материалын жагсаалтыг гаргасан байна.	

		хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэх, ариутгах үйл явц	2.Бохир хэсэгт багаж, хэрэгсэл, материалыг хүлээн авах , цэвэрлэж халдваргүйжүүлэх, хатаах үйл ажиллагааг гүйцэтгэдэг	
			3.Анхан шатны маягтыг бүрэн хөтөлдөг	
			4.Цэвэр хэсэгт багаж хэрэгслийн арчилгаа, савлагаа, ариутгалыг хийдэг.	
		5.5.Багаж хэрэгслийн арчилгаа хийж, хэрэглэх байдлаар савладаг байх	1. Давтан хэрэглэж байгаа багажийн эвдрэл гэмтэл, гажилтыг засдаг, зэв арилгадаг байх	
			2. Багажид тосолгоо хийдэг	
			3. Багажийг хэрэглэх байдлаар багцалж савладаг	
		5.6.Ариутгалын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байх	1. Цэвэрлэгээний үр дүнг уураг болон цусны үлдэгдэл тодорхойлох тестээр сард 1-ээс доошгүй удаа хянадаг	
			2. Боолт, савлагаатай багаж бүрд гадна индикатороор хяналт тавьдаг	
			3. Боолт, савлагаатай багаж бүрийн дотор талд индикатороор хяналт тавьдаг	
			4. Автоклавын камер доторх уурын тархалтыг долоо хоногт 1-ээс доошгүй удаа хянадаг	
			5. Автоклавын үйл ажиллагааг өндөр хэмд тэсвэртэй нянгийн тестээр сард 1-ээс доошгүй удаа хянадаг	
			6. Усны чанарт шинжилгээ хийлгэсэн, дүгнэлттэй	
		5.7. Ариун материалын хадгалалт	1.Ариун материал хадгалах шүүгээтэй.	
			2.Хадгалах, зөөх явцад сав баглаа боодол цоорох, нээгдэх эрсдэлгүй	
			3.Хадгалалтын хугацааг мөрддөг	
			4.Ариун материал хадгалах хэсэгт өрөөний хэм, чийгшлийг хэмжиж, бүртгэл хөтөлдөг.	
		5.8. Шүдний өрмийн бариул ба бусад туслах багаж, хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт,	1. Хурдан болон удаан эргэлтийн өрмийн бариул, мэс заслын өрмийн бариул, өнгөлгөөний резинэн бариул, шулуун өрмийн бариул, ультрасоник, чулуу авагчийн хошуу болон бариул, сувгийн өрмийн бариулыг үйлчлүүлэгч бүрд хэрэглэсний дараа цэвэрлэж, халдваргүйжүүлж, ариутгадаг.	

		ариутгалыг зааврын дагуу хийдэг		
		5.9.Ариутгалын ажилтны сургалтын байдал	1. Ариутгалын ажилтан нь мэргэжил олгох сургалтад хамрагдсан.	
Онооны дүн		Авбал зохих оноо		
		Авсан оноо		
6.	Нүүр амны тусламж үйлчилгээний усны системийн аюулгүй байдлыг хангасан байна.	6.1. Нүүр амны тусламж үйлчилгээний усны системийн аюулгүй байдал	1. Шүдний өрмийн төхөөрөмж, хэт авиан цэвэрлэгч, үйлчлүүлэгчийн нүүр амны эмчилгээ, ам зайлахад ундны усанд тавигдах шаардлага хангасан, шүүсэн ус хэрэглэдэг	
			2. Мэс заслын үйл ажиллагаанд ариун ус хэрэглэдэг. (Биопси, шүдний мэс засал, шүдний оройн мэс засал, имплант, шүдийг мэс заслын аргаар авах гэх мэт.)	
			3. Ажил эхлэхийн өмнө өдөр бүр усны шугам хоолойгоор ус ба хийг дор хаяж 2 минутын турш гүйлгэнэ.	
			4. Усны системд шүүлтүүрийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу тогтмол сольдог, баримтжуулдаг.	
			5. Тухайн өдрийн сүүлийн үзлэгийн дараа үзлэгийн орны усны шугамын хоолойг зориулалтын халдваргүйжүүлэх бодисоор үйлдвэрлэгчийн зааврын дагуу халдваргүйжүүлэлт хийдэг.	
			6. Үзлэгийн орны төхөөрөмжийн усны савыг тогтмол угааж, халдваргүйжүүлж, хатаадаг.	
		6.2. Нүүр амны тусламж үйлчилгээний усны системийн хяналт	1. Усны системийн усыг жилд 2 удаа шинжилгээнд өгч, нян судлал, химийн үзүүлэлтийг шинжлүүлэн баримтжуулдаг.	
Онооны дүн		Авбал зохих оноо		
		Авсан оноо		
7.		7.1.Байгууллагын орчинд цэвэрлэгээг	1.Цэвэрлэгээ хийх зааврыг үйл ажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулж баталсан	

	Эмнэлгийн орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт	зааврын дагуу хийдэг байх	2.Өрөө, тасалгааг бүсээр ангилан тэмдэгжүүлж, бүс тус бүрд тохирсон цэвэрлэгээг бохирдсон тухай бүр хийдэг.	
			3. Цэвэрлэгээ хийх давтамжийг мөрддөг	
			4. Үзлэг, эмчилгээний өрөөнд өдөр тутамд хийгдэх цэвэрлэгээг батлагдсан загвар хуудасны дагуу үнэлж, дүгнэдэг	
			5. Тоног төхөөрөмжийн солих боломжгүй хүрэлцэх гадаргуу, ус, агаар, соруулагчийн бариул, ломбо, шарах гэрлийн аппаратын хошуу, эмчилгээний өрөөний компьютерын гар, товчлуурыг халдваргүйжүүлж нэг удаагийн хамгаалалтын наалт наадаг.	
			6. Үзлэг бүрийн дараа хамгаалах наалтыг шинээр сольдог.	
		7.2.Цэвэрлэгээний материалын хадгалалт, цэвэрлэгээ халдваргүйжүүлэлт	1. Цэвэрлэгээний материал бүхий тэргэнцэртэй, үзлэг эмчилгээний хэсэг болон бусад хэсэг хооронд цэвэрлэгээний материалыг сольж хэрэглэдэггүй	
			2.Цэвэрлэгээнд хэрэглэдэг өнгөөр ялгасан даавуун алчуурыг зориулалтын дагуу хэрэглэж, цэвэрлэж, халдваргүйжүүлэн хадгалдаг	
			3.Цэвэрлэгээний материалыг хадгалах цэгтэй, өрөөтэй	
			4. Цэвэрлэгээнд хэрэглэсэн багаж хэрэгсэл, материалыг хэрэглэсний дараа халдваргүйжүүлж, угаалгын нунтаг бүхий уусмалаар угааж, цэвэр усанд зайлж хатаах боломж, нөхцөлийг бүрдүүлсэн	
			5. Цэвэрлэх, халдваргүйжүүлэх бодисын хэрэглэх арга, өтгөрүүлэг, үйлчлэх хугацаа, аюулгүй ажиллагааны зааврыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу мөрддөг.	
	6.3.Эмнэлгийн өрөө, тасалгаанд шавж, мэрэгч үүрлээгүй, урьдчилан сэргийлэх устгалыг хийлгэдэг байх	1. Эмнэлгийн өрөө, тасалгаа, дээвэр, хонгилд шавж, мэрэгч үүрлэхээс сэргийлж шавж, мэрэгч устгалыг жил бүр хийлгэсэн		
		2. Үүрлэсэн тохиолдолд тухай бүр устгал хийлгэдэг.		
	Онооны дүн		Авбал зохих оноо	
			Авсан оноо	

8.	Шинэ вирусийн халдвар, халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдал.	8.1. Халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх менежменттэй	1. Хүлээлгийн хэсэгт үйлчлүүлэгчид зориулсан амьсгалын замын халдвараас сэргийлэх санамж, анхааруулга, цаасан алчуур, амны хаалт, гар халдваргүйжүүлэгч, хогийн сав байрлуулсан	
			2. Сүрьеэ болон бусад амьсгалын замын халдварын шинж тэмдэг илэрч байгаа эсэхийг үйлчлүүлэгчээс асуумж судалгаа болон шинж тэмдгийн тандалт хийдэг	
			3. Тусламж үйлчилгээ үзүүлэхийн өмнө үйлчлүүлэгч бүрийн амны хөндийг спирт агуулаагүй, бичил биетний эсрэг үйлчилгээтэй ам зайлах уусмалаар зайлуулдаг	
			4. Уушгины идэвхтэй сүрьеэ, салхинцэцэг, улаанбурхан болон бусад цочмог халдварт өвчтэй үйлчлүүлэгчийн хуваарийг зохицуулдаг	
			5. Үйлчлүүлэгч улаанбурхан, салхинцэцэгийн халдвартай бол тухайн халдварын эсрэг дархлаатай ажилтан тусламж үйлчилгээ үзүүлдэг	
			6. Уушгины идэвхтэй сүрьеэ, салхинцэцэг, улаанбурхан зэрэг агаар дуслын замаар дамжих халдвартай үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээг агаарын сөрөг даралттай, НЕРА шүүлтүүртэй өрөөнд үзүүлдэг. Тусламж үйлчилгээний үед раббер дам ашигладаг.	
		8.2. Хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцтэй байх	1. Шүүлтүүртэй амны хаалт, нэг удаагийн амны хаалт, комбинзон, халаад, нүдний шил, нүүрний хамгаалалт, хормогч, ханцуйвч, гутлын гадуурх улавч, бээлий зэрэг нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөцийг хүрэлцэхүйц хэмжээгээр бүрдүүлсэн	
			2. Хамгаалах хувцас хэрэгслийн үзүүлэлт, чанар нь халдвартай орчинд хэрэглэх шаардлага хангасан	
Онооны дүн		Авбал зохих оноо		
		Авсан оноо		
9	Хог хаягдлын менежментийг	9.1.Хог хаягдлыг зохих журмын дагуу	1.Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, зөөвөрлөх, түр хадгалах, устгах зааврыг үйл ажиллагааныхаа онцлогтой уялдуулан боловсруулж, баталсан	

	зохион байгуулсан байна.	зөв ангилан ялгаж цуглуулдаг байх	2.Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зөв ангилсан.		
			3. Хог хаягдал цуглуулах уут савыг зөв өнгөөр ялгасан.		
			9.2.Аюултай хог хаягдлыг зөөвөрлөх, хадгалах үйл ажиллагаа	1.Аюултай хог хаягдлыг эмнэлэг дотор зөөвөрлөх хамгийн оновчтой чиглэлийг тогтоосон	
				2.Ууттай хог хаягдлыг түр хадгалах байр/ цэг хүртэл тагтай, бариултай, "Биоаюултай" таних тэмдэг бүхий саванд хийж зөөвөрлөдөг	
				3.Ууттай хог хаягдлыг ил задгай орхиж, энгийн хог хаягдалтай хамт зөөвөрлөдөггүй	
				4. Хог хаягдлыг түр хадгалах байр, цэг нь шаардлага хангасан	
		9.3. Аюултай хог хаягдлыг цуглуулах, зөөх уут сав нь чанарын шаардлага хангасан байх	1. Зориулалтын аюулгүй хайрцагтай (шингэн нэвчээгүй, зүү нэвтэрдэггүй)		
			2.Аюултай хог хаягдлыг цуглуулах зориулалтын шар, хүрэн өнгийн таних тэмдэг бүхий уут, хогийн сав ашигладаг, нөөцтэй байх		
			3. Хогийн сав нь гар оролцохгүй нээж, хаагддаг		
		9.4.Аюултай хог хаягдлын устгалыг зөвшөөрөл бүхий байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлдэг байх	1. Аюултай хог хаягдлыг устгах эрх бүхий байгууллагатай гэрээтэй ажилладаг		
			2. Гэрээний хэрэгжилтийг хянадаг		
			3. Эмнэлгээс гарч байгаа аюултай хог хаягдлын хэмжээг нэгтгэн сар бүр мэдээлдэг		
		Онооны дүн	Авбал зохих оноо		
			Авсан оноо		

Хүснэгт 4.

Нүүр амны тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын үнэлгээний нэгдсэн дүн

Огноо:

Эрүүл мэндийн байгууллагын нэр:

Хаяг:

Бүлэг	Шалгуур үзүүлэлтийн тоо	Авбал зохих оноо	Авсан оноо
1. Халдварын сэргийлэлт, хяналтын бодлого, шийдвэрийн хэрэгжилт			
2. ЭМА-ыг халдвараас сэргийлэх үйл ажиллагаа			
3. Үйлчлүүлэгчийг халдвараас сэргийлэх үйл ажиллагаа			
4. ЭТҮХХ илрүүлэх тандалт, дүгнэлт, хариу арга хэмжээ			
5. Ариутгал, цэвэр, аюулгүй байдлыг хангасан багаж хэрэгслээр тусламж			
6. НАТУ-ий усны системийн аюулгүй байдал			
7. Эмнэлгийн орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт			
8. Шинэ вирусийн халдвар, халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн үеийн ноцтой байдлын үеийн бэлэн байдал			
9. Хог хаягдлын менежментийн зохион байгуулалт			
Нийт оноо			
Хувь			

Үнэлсэн мэргэжилтэн /байгууллага/:

Хяналт тавьсан мэргэжилтэн /байгууллага/:

Танилцсан:

**Нүүр амны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг
хангахад баримтлах нийтлэг заавар**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Нүүр амны тусламж, үйлчилгээ (цаашид НАТҮ гэх) үзүүлж буй өмчийн хэлбэр харгалзахгүй бүх эрүүл мэндийн байгууллага Нүүр амны тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдал (НАТҮЧАБ)-ын нийтлэг зааврыг дагаж мөрдөнө.
- 1.2. Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу эрүүл мэндийн бүх байгууллагуудад “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба/баг” (цаашид ЭМТҮЧАБ гэх) ажиллана.
- 1.3. ЭМТҮЧАБ-ын алба/баг нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, тушаал, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.
- 1.4. Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал хариуцсан нэгж нь НАТҮЧАБ-ын үнэлгээг жил бүр хийж, тайланг 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Хоёр. Нүүр амны тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын тогтолцоо

- 2.1. Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлж буй бүх түвшний эмнэлгүүд ЭМТҮЧАБ-ын холбогдох тушаал болон зааврыг хэрэгжүүлж ажиллана.
- 2.2. Нүүр амны тусламж үйлчилгээний тусгай мэргэжлийн төвд тусламж, үйлчилгээний цар хүрээ, бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний төрөл, үйлчлэх хүрээний хүн амын тоо зэргээс хамаарч 3-5 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны ЭМТҮЧАБ-ын албыг байгуулж ажиллана. Үүнд: Албаны дарга, аюулгүй байдлын менежер, эрсдэлийн менежер, лавлагаа мэдээллийн ажилтан зэрэг бүрэлдэхүүнтэй байхаар зохион байгуулна. Клиникийн 3-4 эмнэлэг өөрийн тусламж үйлчилгээний цар хүрээ болон онцлогоос шалтгаалан ЭМТҮЧАБ-ын албыг хамтран байгуулж ажиллаж болно. НАТҮЧАБ-ын алба/багийн ахлагч нь үндсэн болон гэрээт ажилтан байж болно.
- 2.3. Тус алба/баг нь нүүр амны тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоо, тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах, чанарыг тасралтгүй сайжруулах, чанар, аюулгүй байдлын хяналт, үнэлгээг тогтмолжуулахад анхаарч, үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.
- 2.4. Тухайн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй алба/баг нь НАТҮЧАБ-д тогтмол хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж арга зүйн дэмжлэг үзүүлэх, тусламж үйлчилгээний эрсдэлийг тооцож, авах арга хэмжээг төлөвлөх, эмч, мэргэжилтнүүдэд чанар, аюулгүй байдлын чиглэлээр дэмжин туслах, арга зүйн зөвлөгөө өгөх, чанар сайжруулах чиглэлээр тасралтгүй сургалтыг зохион байгуулах, албаны төлөвлөгөө

гарган хэрэгжүүлэн ажиллах, бусад албадын (Халдварын сэргийлэлт хяналтын баг, ёс зүй баг гэх мэт) үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагаандаа татан оролцуулах, эрүүл мэндийн мэргэжилтэн болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах ОУ-ын туршлагыг нэвтрүүлэх, үүрэг бүхий нэгж байна.

2.5. Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллага нь дотоодын болон олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн чанарын баталгаажуулалтад хамрагдаж болно.

Гурав. Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулахад баримтлах зарчим

3.1. Үйлчлүүлэгчийн мэдээллийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй маягтын дагуу бүртгэлийг бүрэн, зөв хийнэ

3.2. Үйлчлүүлэгчийг таних 2 аргыг нэвтрүүлж ажилбар хийхээс өмнө үйлчлүүлэгчийг зөв танина. /овог нэр, амны хөндийн онцлог, толиор харуулах /авхуулсан шүд, ломбо, сувгийн эмчилгээ//. Нэмэлтээр тухайн эмнэлэгт бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, утасны дугаар зэрэг байж болно;

3.3. Үйлчлүүлэгчийг таних тэмдгүүдийг олон төрлөөр нэвтрүүлэх. /анхан ба давтан үзлэгээр, насны ангиллаар, хүйсээр, тусгай хэрэгцээт иргэний, эмчилгээ ба мэс засал, амны хөндийн үзлэг гэх мэт/;

3.4. Тусламж үйлчилгээ үзүүлэхээс өмнө ажилбар болон эмчилгээ шаардлагатай шүдийг /дугаараар нь/ дахин баталгаажуулна. Нүүрний толь ашиглах, өвдөлтийн онцлогийг танилцуулах (дамжсан өвдөлт өгдөг гэх мэт)

Дөрөв. Үйлчлүүлэгчтэй эмнэл зүйн, үр дүнтэй харилцаа

4.1 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар мэдээллээр хангах орчныг бүрдүүлсэн байна;

4.2 Эмнэлгийн эмч, ажилтны ажиллах орчны аюулгүй байдлыг хангасан мэдээлэл дамжуулах дэд бүтцийг бий болгосон байна /Сувилагч дуудах, гал унтраах, нэвтрэлтийн хязгаарлалтын систем буюу нууц үг, код ашиглах, камерын хяналт, зарлан дуудах системүүд орно/;

4.3 Тусламж үйлчилгээ үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдээллийг ил тод байршуулсан байна;

4.4 Тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчид ойлгомжтой хэллэгээр, зөв, товч тайлбарлах ур чадвартай байна;

4.5 Үйлчлүүлэгчийг эмч хооронд болон эмнэлэг хооронд шилжүүлэх журамтай байна;

4.6 Үйлчлүүлэгчийн мэдээллийг эмч мэргэжилтний хооронд зөв бүтэн дамжуулах явцын журамтай байна. Мэдээллийг дамжуулахад бичгээр болон аудио, видео хэлбэрээр тэмдэглэл хөтөлнө;

4.7 Үйлчлүүлэгч түүний ар гэрийнхэн, асран хамгаалагчид мэдээллийг ойлгомжтой, бодитой, үнэн зөв тайлбарлан таниулдаг байна;

4.8 Үйлчлүүлэгчтэй эмнэл зүйн, үр дүнтэй харилцааны 7 зарчмыг баримтална:

4.8.1 Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийн ар гэрийнхэнд мэдээллийг өгөх;

4.8.2 Үйлчлүүлэгчид дамжуулах чухал шаардлагатай мэдээллийг агуулсан материал, гарын авлага, ашиглах;

- 4.8.3 Энгийн үг хэллэг ашиглах;
- 4.8.4 Өгсөн мэдээллээ эргүүлэн асуух;
- 4.8.5 Орчуулагч эсвэл хэлмэрчийг оролцуулах;
- 4.8.6 Шаардлагатай тохиолдолд багаар ажиллах;
- 4.8.7 Асуух, тэмдэглэх боломж олгох.

4.9 Үзлэг, оношилгоо болон ажилбарын өмнөх үйлчлүүлэгчийг танин тодруулах үйлдэл /цусны даралт, амин үзүүлэлт, хавсарсан эмгэг байгаа эсэхийг асуумж хуудсаар урьдчилан авч эрсдэлийг үнэлэх/;

4.10. Үзлэг хийхийн өмнө болон эмчилгээний явц, дууссаны дараах үеийн тайлбар, зөвлөгөө, гарч болзошгүй эрсдэл, хүндрэлийн талаар ойлголт зөвлөгөөг тодорхой өгөх, ойлгосон эсэхийг эргэн асуудаг байна.

Тав. Өндөр эрсдэлтэй эмийн аюулгүй байдлыг хангах

5.1 Нүүр амны тусламж үйлчилгээний тусгай мэргэжлийн төвд түгээмэл хэрэглэдэг эм, тариа, материал, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтийн журамтай байна, клиникийн эмнэлгүүдэд орлого зарлагын хуудсаар зохицуулалт хийж болно;

5.2 Өндөр эрсдэлтэй, ижил харагдах, ижил дуудагдах эмийн жагсаалттай байна. Эм эмнэлгийн хэрэгслийн хаягжилт, шошгололтод хяналт тавин ажиллана;

5.3 Тарилгын аюулгүй байдлыг баримталж байршуулах, халдварын эрсдэлээс сэргийлэх, холбогдох журмыг мөрдөх;

5.4 Тусламж, үйлчилгээнд хэрэглэж буй эм, эмийн бодисын гаж нөлөөнөөс зайлсхийж, үйлчлүүлэгчид хэрэглэж байгаа эм, эмийн бодист харшилтай эсэхийг асуумжаар тодруулан, эрсдэлтэй гэж үзсэн үйлчлүүлэгчид шаардлагатай тохиолдолд сорил тавьж ажиллах;

5.5 Хэсгийн мэдээгүйжүүлэлт хийсний дараа өвчтөнийг бүрэн хянадаг байх /үзлэгийн өрөөг орхин гарахгүй байх/;

5.6 Хэсгийн мэдээгүйжүүлэлт нь өндөр эрсдэлтэй эмийн бүлэгт хамаарах тул тун болон хэрэглэсэн ампулын тоог тэмдэглэж, хяналтын тогтолцоотой байна.

Зургаа. Нүүр амны мэс заслын аюулгүй байдлыг хангах

6.1 “Зөв таньж, зөв ажилбарыг, зөв эрхтэнд, зөв цагт нь хийнэ” гэсэн зарчмыг баримтална;

6.2 Мэс засал мэс ажилбар хийхийн өмнөх тайлбарыг тодорхой өгөх, ойлгосныг тодруулах, сонголт хийх боломж олгон, зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зуруулна;

6.3 Нүүр амны мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлсний дараа хэрэглэсэн багаж, хэрэгсэл, ариун материалыг нэг бүрчлэн тоолж, хяналт тавина;

6.4 Шүд авах мэс ажилбар хийхийн өмнө авах шүдийг танин тодруулах үйлдэл хийнэ. Ажилбар хийхийн өмнө ба дараа тухайн шүдийг үйлчлүүлэгчид харуулж ажилбар гүйцэт хийсэн байдлыг таниулна;

6.5 Жирэмсэн болон эрсдэлтэй үйлчлүүлэгчид хийгдсэн хүндрэлтэй шүд авалт, мэс ажилбарын дараах хяналт тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, давтан үзлэгээр хянах

Долоо. Үйлчлүүлэгчийг унах эрсдэлээс сэргийлэх

7.1 Эмнэлгийн удирдлага нь үйлчлүүлэгчийг эмнэлгийн орчинд унах эрсдэлийг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ;

7.2 Эмнэлгийн дотоод орчинд унахаас сэргийлж шатны эхний болон сүүлчийн гишгүүрийг тодосгож тэмдэглэнэ. Шал угааж буй үед "нойтон шал" гэсэн санамж тавина. Ариун цэврийн өрөөнд унахаас сэргийлж гарын бариул байршуулна. Шалны бүрэн бүтэн байдлыг хангана, шалны эвдрэлтэй хэсэг, урагдсан хулдаасыг тухай бүрд нь сольж, хаалганд босгоноос татгалзана;

7.3 Шаардлагатай үйлчлүүлэгчид унах эрсдэлийн үнэлгээг стандартын дагуу хийж, өндөр эрсдэлтэй үйлчлүүлэгчид "гараас гарт" зарчмаар тусламж үйлчилгээг үзүүлнэ.

Найм. Тоног төхөөрөмжийн аюулгүй байдал

8.1. Нүүр амны тусламж, үйлчилгээнд ашигладаг тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангахад хариуцан ажиллах инженерийг томилох, гэрээ хийх, засвар үйлчилгээг тогтмол хуваарийн дагуу хийлгэж, баримтжуулсан байх;

8.2. Тоног төхөөрөмж бүрийн ашиглалтын заавар болон аюулгүй ажиллагааны зааврыг баталгаажуулан, байршуулсан байх;

8.3. Ашиглалтын дараах цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн заавартай байх;

8.4. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг жилд 2-с доошгүй удаа эмч, мэргэжилтнүүдэд өгдөг байх;

8.5. Хэмжээст тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж, тогтмол хугацаанд зохих байгууллагаар баталгаажилт хийсэн байх;

8.6. Тоног төхөөрөмжийн газардуулгыг шалгаж, тэмдэглэл хөтлөн, баримтжуулсан байна.

Ес. Цацрагийн аюулгүй байдал

9.1 Рентген оношилгооны кабинетыг байгуулах, тоног төхөөрөмжийг суурилуулах, зохион байгуулах ажилд тавигдах шаардлагыг хангасан байна;

9.2 Рентген оношилгоо, эмчилгээ хийх үед мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм заавартай байна;

9.3 Үйлчлүүлэгч, өвчтөний авах цацрагийн шарлагын тунг тодорхойлох арга, багаж хэрэгсэл нь цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн байх.

Арав. Эмнэл зүйн аюулгүй байдал

10.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэлд тохирсон оношилгоо, эмчилгээний жагсаалтыг гаргаж баталгаажуулсан байна;

10.2 Жагсаалтад орсон үйлчилгээний холбогдох батлагдсан удирдамжийг хэвлэмэл байдлаар бэлдсэн байх (хэрэв Монгол улсад батлагдсан удирдамж байхгүй тохиолдолд хуулийн хүрээнд олон улсад нэвтэрсэн стандарт, удирдамжид үндэслэн боловсруулж мэргэжлийн нийгэмлэг, холбоод, ЭМЯ-ны дэргэдэх НАСМС Зөвлөлөөр хянуулан, захирлаар батлуулан мөрдөнө);

10.3 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь удирдамж, заавар, стандартыг өдөр тутмын зүйл ажиллагаанд мөрдөн ажиллана

- 10.4 Эрсдэлтэй ажилбарын жагсаалт, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний удирдамжтай байна;
- 10.5 Эмнэл зүйн, удирдамж, зааврын мөрдөлтөд хяналт тавьж ажилдаг байна;
- 10.6 “Тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах” журамтай байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх журмын дагуу цахимаар бүртгүүлэх
- 10.7 “Эрсдэлийг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах” журамтай байна. Эмнэлэг нь тухайн жил бүр эрсдэлийн үнэлгээ хийж, бууруулах төлөвлөөг холбогдох тушаалын дагуу баталж ажиллана.;
- 10.8 Эмчилгээ, үйлчилгээний онцлог байдлыг тусгасан таниулсан зөвшөөрлийн хуудас боловсруулж байгууллагын захирлаар батлуулан үйлчлүүлэгчид танилцуулна;
- 10.9 Тухайн эмнэлэгт үзүүлж буй тусламж үйлчилгээ бүрд зориулан үйлдлийн хяналтын хуудастай байна. Хяналтын хуудсыг чанарын хяналт, дотоод хяналт, ижил мэргэжилтний үнэлгээ хийхэд ашиглана;
- 10.10 ЭМТҮЧАБ-ын баг, алба нь тухайн харьяаны эмнэлгүүдэд хөндлөнгийн хяналтыг тавина. Хөндлөнгийн хяналтын хуваарь батлуулж, хуваарийн дагуу хяналт гүйцэтгэсэн тайлан гаргаж ажиллана;
- 10.11 Эмнэлгийн удирдлага нь амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний сургалтыг эмч, эмнэлгийн ажилтнуудад тогтмол зохион байгуулж, амилуулах суурь тусламж үзүүлэх мэдлэг ур чадварыг дээшлүүлдэг байна;
- 10.12 Үйлчлүүлэгчийн амь тэнссэн нөхцөл байдал үүссэн тохиолдолд амин үзүүлэлтийг тогтворжуулах арга хэмжээг шуурхай авч, дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад хүргэх, боломжгүй нөхцөлд түргэн тусламж дуудан холбогдох эрүүл мэндийн байгууллагад хүргүүлдэг үүрэгтэй байна;
- 10.13 Байгууллагын үзүүлж буй тусламж, үйлчилгээний нэр төрөл хүний нөөцийн мэдээллийг ил байршуулсан байна;
- 10.14 Ижил мэргэжилтний үнэлгээг тухайн байгууллагын эмч мэргэжилтнүүд болон хөндлөнгийн эмч, мэргэжилтнээр хийлгэнэ.
- 10.15 Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлдэг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд нэг үйлчлүүлэгчид хамгийн багадаа 30 минут зарцуулахаар тооцож цаг олгоно.

Арван нэг. Нүүр амны тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын хяналт, шинжилгээ, үнэлгээ

- 11.1. Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлж буй эмнэлгүүдэд хяналт үнэлгээ шинжилгээг хөндлөнгийн болон дотоодын хяналт байдлаар хийх ба хөндлөнгийн хяналт нь харьяа дээд шатны байгууллагуудаас тусгай шалгуур хуудасны дагуу хийгдэнэ. Тухайн эмнэлгийн чанар аюулгүй байдлын баг нь хөндлөнгийн хяналт, шинжилгээ үнэлгээ, хяналтын дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажиллана.
- 11.2. Хөндлөнгийн хяналтыг мэргэжлийн нийгэмлэг холбоод, төрийн болон төрийн бус байгууллагын нүүр амны тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын чиглэлээр дадлага туршлагатай ажилтныг оролцуулан, байлцуулан хийж болно.

11.3. Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлэгч эмнэлэг нь тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хянах, сайжруулах тухайн салбарт мөрдөж буй стандарт, журам, заавар, удирдамжийг мөрдүүлэх хэрэгжилтийг хангуулах, дээрх бичиг баримтад үндэслэн ач холбогдол, эрсдэлийн зэргийг харгалзан НАТҮЧАБ-ын чиглэлээр дадлага туршлага бүхий баг /ажилтан/ хуульд нийцүүлэн боловсруулсан тусгай хяналтын хуудсаар хяналт үнэлгээ шинжилгээг хийж цаашид авах арга хэмжээг төлөвлөн ажиллаж ба тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулна.

11.4. Нүүр амны тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын эмнэлгийн дотоод дахь хяналтыг “Нүүр амны тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үлгэрчилсэн үнэлгээ”-ээр үйл ажиллагааг үнэлэх, хянах, НАТҮЧАБ-ыг сайжруулах зорилгоор ашиглаж болно.

11.5. НАТҮЧАБ-ын үнэлгээнд хамрагдсан эрүүл мэндийн байгууллага нь тусламж үйлчилгээний тохиолдлыг бууруулах зорилгоор дүн шинжилгээ хийн, хариу арга хэмжээ авч, НАТҮЧАБ-ыг сайжруулах үүрэг хүлээнэ.

Арав хоёр. Нүүр амны тусламж үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлэх нь

12.1. Нүүр амны эмнэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ оношийг ОУ-ын 10-р ангиллын дагуу (тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй оношны ангиллаар), ялган оношилгоог сайтар хийсний үндсэн дээр, давтан ирэлт шаардах эмчилгээг хийхгүй байх зарчмыг баримтлан ажиллах ба шүдний сувагт зайлшгүй нэвтрэх тохиолдолд заавал ариутгасан багаж ашиглана. Нэг удаагийн багаж ашиглахыг хатуу хориглоно.

12.2. Явуулын багийн хүний нөөц, мэргэжилтний мэргэшсэн бэлтгэгдсэн байдал, иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрөл, багаж тоног төхөөрөмжийн тоо, хүрэлцээ, багажийн ариутгалын байдал зэргээс хамааран өдөрт тусламж үйлчилгээ үзүүлэх иргэдийн болон НАТҮ-ний тоог хязгаартайгаар тогтоон, хүсэлт илгээн батлуулах.

12.3. Явуулын үзлэгийн үеэр нүүр амны анхан шатны тусламж үзүүлэх шаардлагатай буюу зөөлцийн үрэвсэл, сурвалжийн оройн үрэвсэл, шүдний гэмтэл, шүдний хөндий нээгдсэн үед яаралтай арга хэмжээ авч болно. Ингэхдээ үйлчлүүлэгчид өвчний онош, онцлог байдал, давтан ирэлтдээ хугацаандаа харьяа эмнэлэгтээ хамрагдах нэн шаардлагатайг тайлбарлан, таниулах зөвшөөрлийн хуудсыг бөглөн дараагийн эмнэлэгт шилжүүлж болно.

12.4. Явуулын хэлбэрээр нүүр амны эмнэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх ажилбарууд

12.4.1. Шүдний ховил битүүлэх ломбо (сийлант)

12.4.2. Шүдний фторт түрхлэгүүд болон бусад урьдчилан сэргийлэх бэлдмэлүүдийг түрхэх

12.4.3. Шүд цоорох өвчний нөхөн сэргээх эмчилгээ (шүд ломбодох)

12.4.4. Шүдний буйлны дээрх чулууг өнгөлж цэвэрлэх

12.4.5. Хүндрэлгүй шүд авалт

12.4.6. Амны салстын өвчнүүд

12.4.7. Авагддаг хиймэл шүдэлбэр хийх

12.5. Явуулын нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай багаж хэрэгслийн жагсаалт, тоо хэмжээ:

12.5.1. Зөөврийн суудал

12.5.2. Зөөврийн иж бүрэн хэрэгсэл бүхий чемодан

12.5.3. Зөөврийн бага эсвэл дунд оврын тосгүй компрессор

12.5.4. Зөөврийн рентген

12.5.5. Багажийн тавиур

12.5.6. Ломбо хатууруулагч гэрлийн аппарат

12.5.7. Рентген сенсор, PSP/уламжлалт рентген хальс боловсруулалт

12.5.8. Зөөврийн шүлс соруулагч аппарат

12.5.9. Өрмийн бариул ариутгагч автоклав

12.5.10. Багаж хэрэгслийг цэвэрлэх чичиргээт машин (ультрасоник)

12.5.11. Хүүхдийн хөдөлгөөн хязгаарлагч хавтан

12.5.12. Микромотор

12.5.13. Чулуу авагчийн бариул – заавал ариутгаж ашиглана

12.5.14. Шүдний эмчилгээний иж бүрдэл

12.5.15. Мэдээ алдуулах төмөр тариур

12.5.16. Шүд авах иж бүрдэл

12.5.17. Үзлэгийн пинцепт (цэврийн)

12.5.18. Шүдний төрөл бүрийн өрмийн толгой

12.5.19. Хурдан болон удаан эргэлтэд өрмийн бариул

12.5.20. Бусад шаардлагатай багаж, хэрэгсэл

12.5.21. Багаж хэрэгсэл, материал ариутгах автоклав

12.5.22. 12.3–т заасан тохиолдолд буюу нэн шаардлагатай тохиолдолд ашиглах багаж, тоног төхөөрөмж

12.5.23. Шүдний суваг хэмжигч (Dental Apexlocator – Rootmeter)

12.5.24. Шүдний сувгийн файл, зөөлц сугалагч, канал наполнитель, бусад хэрэгсэл

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
.... дугаар сарын-ны өдрийн
дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

НҮҮР АМНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭМНЭЛГИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Огноо:

Эрүүл мэндийн байгууллагын нэр:

Хаяг:

БҮЛЭГ 1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ: 0 – байхгүй 1 – дунд 2 – сайн
Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, мэдээлэл өгөх				
1.	Байгууллага нь Үйлчлүүлэгчийн эрхийг хүндэтгэж үйлчлүүлэгчтэй харилцах, холбоо тогтоох, мэдээлэл өгөх тогтолцоог бүрдүүлсэн байна.	Үйлчлүүлэгчээс амаар, утсаар мэдээлэл авах, мэдээлэл өгөх Цаг товлох үйлчилгээ , үйл явцыг тодорхойлж, баталгаажуулсан, хэрэгжүүлдэг байх	1. Үйлчлүүлэгчээс амаар /биечлэн ирэх/ болон утсаар мэдээлэл, /үзлэгийн захиалга/ авах, өгөх журамтай, баталгаажуулсан байх	
			2. Утсаар болон цахимаар үзлэг, оношилгооны цаг товлох захиалгыг авдаг байх	
			3. Цаг товлох үйлчилгээнд өөрчлөлт гарсан тохиолдолд үйлчлүүлэгчид эргэн мэдээлж, тэмдэглэдэг байх	
2.		Оношилгоо, эмчилгээтэй холбоотой мэдээллийг үйлчлүүлэгчид үнэн, зөв өгдөг байх	1. Үйлчлүүлэгч болон гэр бүлийнхэнд үнэн, зөв дараах мэдээллийг өгдөг байх: - эмчилгээ, оношилгоо хийж байгаа мэргэжилтний нэрс, ажлын туршлага - эмчилгээ, ажилбар, үйлдлийн явц, үр дүн - үзүүлсэн тусламж үйлчилгээнд гарч болох хүндрэлүүд гэх мэт	

3.		Үйлчлүүлэгч эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл авах нөхцөлөөр хангасан байх	1. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт хийх, шаардлагатай хэрэгслээр хангасан байх	
			2. Хүлээлгийн танхимд халдварт бус өвчин амны хөндийн эрүүл мэнд өвчнөөс урьдчилсан сэргийлэх гарын авлага, брошур байлган унших боломжоор хангах	
			3. Бага насны хүүхэд түүний асран хамгаалагчид шүд зөв угаах арга техник заах нөхцөл бүрдүүлэн, амны хөндийн арчилгааны үнэлгээ хийх, зааж сургах	
4.		Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, гомдлыг боломжит сувгаар хүлээн авч, тухай бүр шийдвэрлэж, эргэн мэдээлдэг байх	1. Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, өргөдөл гомдлыг цахимаар, утсаар, амаар болон бичгээр авдаг, бүртгэл хөтөлдөг байх	
			2. Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийдэг байх	
			3. Хугацаанд нь шийдвэрлэж, хариу өгч, эргэн мэдээлсэн өргөдлийн тоо/хувь	
5.	Эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчинд үйлчлүүлэгч унаж, гэмтэхээс сэргийлэх арга хэмжээ авсан байна.	Эмнэлгийн гадаад, дотоод орчинд үйлчлүүлэгч унаж, гэмтэх эрсдэлээс сэргийлдэг байх	1. Эмнэлгийн гадаад, дотоод орчинд тогтмол үнэлгээ хийж, үйлчлүүлэгч унах эрсдэлийг тогтоодог байх	
			2. Гадаад, дотоод орчинд үйлчлүүлэгч явганаас унаж, гэмтэх эрсдэл үүсэхээс сэргийлэх арга хэмжээг авдаг /зам талбайн бүрэн бүтэн байдал, халтиргаа, гулгаа үүсэх, шат, шатны хонгил, орох хаалганы орчин, шалны материал, бариул гэх мэт/	
			3. Анхааруулга, таних тэмдэг, тэмдэглэгээ нь үйлчлүүлэгчид ойлгомжтой, энгийн, үзэмжтэй байх	
Тусламж үйлчилгээний тасралтгүй байдал				
1.	Нүүр амны тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлдэг байна	Тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх зохион байгуулалтыг хийсэн байна	1. Жирэмсэн болон эрсдэлтэй үйлчлүүлэгчид хийгдсэн хүндрэлтэй шүд авалт, мэс ажилбарын дараах хяналт тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, давтан үзлэгээр хянах	

			2. Тусламж үйлчилгээний хүндрэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор үйлчлүүлэгчийн шаардлагатай мэдээллийг бүртгэж, эргэн дуудах (Re-call) боломжийг бүрдүүлсэн байх.	
	Онооны дүн	Авбал зохих оноо	...	
		Авсан оноо	...	

БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ: 0 – байхгүй 1 – дунд 2 – сайн
Засаглал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлага				
1.	Байгууллагын бүтэц, орон тоог баталж, тусламж, үйлчилгээний чиглэлийн дагуу зохион байгуулсан байна.	Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх бүтэц, зохион байгуулалтыг хийсэн байх	1. Клиникийн эмнэлгийн стандарт дагуу бүтэц, зохион байгуулалтыг баталсан тушаалтай байх.	
			2. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, зөвшөөрлийн хугацаа хүчинтэй байх.	
			3. Үйл ажиллагааг явуулах байршилд үйл ажиллагаа явуулдаг байх.	
2.	Хүний нөөцийг хөгжүүлэх, ёс зүйн хэм хэмжээг мөрдөх арга хэмжээ авч, шийдвэрлэдэг байна.	Хүний нөөцийг ажлын байран дээр тасралтгүй суралцах нөхцөл, боломжоор хангасан байх	1. Ажлын байран дээр суралцах нөхцөлөөр хангаж, сургалт хийх төлөвлөгөөтэй, төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг байх.	
3.		Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг байх	3. Эмнэлгийн мэргэжилтэн бүр ёс зүйн хэм хэмжээг баримталдаг. Ажилтнуудын ажлын үнэлгээнд харьцаа хандлага, ёс зүйн шалгуур үзүүлэлтийг оруулж, дүгнэдэг мөрддөг байх.	
			4. Эмнэлгийн мэргэжилтний харьцаа хандлага, ёс зүйн чиглэлээр сургалт хийдэг байх.	

4	чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байна.	/Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө/-тэй, хэрэгжүүлж, хянадаг байх	1. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг алба/багийн чанар сайжруулах төлөвлөгөөг баталсан байх.	
			2. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэдэг, үр дүнг жил бүр тооцсон, тайлан гаргадаг байх.	
5	тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангахад үйлчлүүлэгч болон ажилтнуудын оролцоог хангасан байна.	Үйлчлүүлэгч болон ажилтнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааг тухай бүр дүгнэдэг, гарсан асуудалд чиглэсэн тодорхой арга хэмжээ авдаг, дүн шинжилгээ харьцуулалт хийж хэвшсэн байх	1. Сэтгэл ханамжийн судалгааны асуумж, арга аргачлалыг баталж, судалгааг тогтмол зохион байгуулдаг байх.	
			2. Сэтгэл ханамжийн судалгаанд дүн шинжилгээ хийн асуудлыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байх.	
6	Эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байна	Эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг тогтмолжуулсан байх	1. Холбогдох журам, зааврын дагуу байгууллагын эрсдэлийг үнэлж, эрэмбэлж, бүртгэдэг байх.	
			2. Үнэлгээнд үндэслэн эрсдэлээс сэргийлэх, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг боловсруулсан, хэрэгжилтийг тооцдог байх.	
7	Халдварын сэргийлэлт, хяналтын талаар гарсан тушаал зааврыг хэрэгжүүлж ажилладаг байна.	Эрүүл мэндийн ажилтныг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авдаг байх	1. Ажилбар хийгддэг өрөө бүрд гар угаах угаалтууртай Тусламж, үйлчилгээ үзүүлэх цэг бүрд гар халдваргүйжүүлэх бодистой байх	
			2. Эрүүл мэндийн ажилтны гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэгийг жилд 1-ээс доошгүй удаа үнэлдэг байх.	
			3. Халдваржуулах бодис зааврын дагуу ашигладаг нөөцтэй байх мөн нэг удаагийн багаж, хэрэгсэл хамгаалах хувцас, бээлийний нөөцтэй байх.	
			4. Ариутгал хийх нөхцөл бүрдсэн эсвэл гэрээгээр гүйцэтгэлцүүлдэг бол бүртгэлтэй байх.	
			5. Халдварын сэргийлэлтийн талаар хяналтын хуудсаар хяналт хийж илэрсэн дутагдлыг арилган ажилладаг байх.	
8	Эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг хийдэг байна.	Эрүүл мэндийн ажилтны дархлаажуулалтын нэгдсэн бүртгэл, судалгаатай,	1. Эрүүл мэндийн ажилтанд хийгдсэн дархлаажуулалтын бүртгэл хөтөлдөг (Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын дархлаажуулалтад хамрагдсан бүртгэлтэй) өвдсөн эсэхийг асуумжаар тодруулдаг байх.	

		дархлаажуулалтад хамруулдаг байх	2. Архаг халдваргүй, эсрэг заалтгүй бол эмнэлгийн ажилтныг В вируст гепатитийн 3 тун вакцинаар дархлаажуулсан В вируст гепатитийн дархлаажуулалтад хамрагдсан ажилтныг дархлаа тогтцын шинжилгээнд хамруулдаг байх.	
9	Байгууллагын мэдээллийн тогтолцоо нь мэдээллийн аюулгүй байдлыг хангасан гадаад, дотоод сүлжээтэй байна.	Байгууллага нь тусламж, үйлчилгээний үзүүлэлтүүд, хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, санхүү зэрэг чиглэлээр үүсгэсэн мэдээний сантай байх	1. Мэдээний сантай, жил бүр баяжилт хийдэг байх.	
			2. Жил бүр дүн шинжилгээ хийдэг байх.	
10		Мэдээллийн аюул хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	1. Байгууллагын болон хувь хүний нууцыг хамгаалсан мэдээллийн аюулгүй байдлыг бүрдүүлсэн байх	
11		Төв нь гадаад сүлжээтэй байнга баяжилт хийгддэг, ашигладаг байх	1. Цахим хуудас, Facebook page хуудастай байх.	
			2. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгодог байх	
12		Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийж, аюулгүй ажиллагааны дүрэм, заавартай, санамжийг холбогдох ажлын байран дээр байрлуулж, хяналт тавьдаг байх	1. Тоног төхөөрөмжийн ашиглалтын бүртгэл, засвар үйлчилгээ хийлгэсэн бүртгэлтэй байх.	
			2. Нүүр амны тусламж үйлчилгээний тоног төхөөрөмж болон яаралтай тусламж үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай хэрэгслээр хангагдсан байх.	
			3. Оношилгоо, эмчилгээнд ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг боловсруулж, баталгаажуулан ажлын байранд байршуулж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилтан танилцуулан баталгаажуулсан байх	
13	Төвийн усан хангамж ,галын аюулгүй байдлыг хангаж ажиллана хэвийн байдлыг хангаж ажилладаг	Байгууллагын усан хангамжийн үйлчилгээ тасралтгүй байх	1. 24 цагийн усан хангамжтай байх. Усны тасалдал гарсан тохиолдолд зохицуулах арга хэмжээг төлөвлөсөн усны шинжилгээтэй, шаардлага хангасан байх.	
14		Галын аюулгүй байдал, гал унтраах техник, хэрэгслийг ашиглах талаар ажилтнуудыг сургалтад хамруулсан байх	1. Байгууллагын хэмжээнд мөрддөг галын аюулгүй ажиллагааны батлагдсан заавартай байх.	
			2. Гал унтраах хэрэгслийг ашиглах дадлага сургуулилт хийсэн, зааврыг өгсөн байх.	

Онооны дүн	Авбал зохих оноо	...
	Авсан оноо	...

БҮЛЭГ 3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ТЕХНОЛОГИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ: 0 – байхгүй 1 – дунд 2 – сайн
Нүүр амны тусламж, үйлчилгээ				
1.	Нүүр амны тусламж, үйлчилгээ үзүүлдэг байна.	Нүүр амны тусламж үйлчилгээний үзлэгийн өрөөнүүдийг зохион байгуулж, үзлэг, оношилгоог бүрэн хийдэг байх	1. Батлагдсан бүтцийн дагуу үзлэгийн өрөөнүүдийг зохион байгуулсан байх.	
			2. Батлагдсан жагсаалт дагуу мэргэшсэн хүний нөөцтэй байх, ялангуяа яаралтай тусламж үзүүлэх 2-оос доошгүй эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй байх , эмчлэх эрхийн хугацаа хүчинтэй байх.	
2.		Тусламж, үйлчилгээ үзүүлэх жагсаалтыг батлан гаргаж заасан төрлөөр нүүр амны тусламжийг үзүүлдэг байх	1. Тусламж, үйлчилгээний жагсаалтыг гаргаж баталсан байх.	
			2. Баталсан жагсаалтын дагуу эмч мэргэжилтний ашиглах удирдамж заавар, гарын авлага цахим ба цаасан хэлбэрээр бэлтгэн ашиглах боломжийг бүрдүүлсэн байх.	
			3. Жагсаалтад заасан нүүр амны тусламж үйлчилгээний төрлийн дагуу үзлэг, оношилгоо, эмчилгээг удирдамж, зааврын дагуу хийдэг байх.	
3.	Нүүр амны тусламж, үйлчилгээг стандарт, удирдамж, зааврын дагуу үзүүлдэг байх	Нүүр амны тусламж, үйлчилгээг стандарт, удирдамж, зааврын дагуу үзүүлдэг байх	1. Эмнэлгийн мэргэжилтнүүдийг хүчин төгөлдөр удирдамж, заавраар хангасан, сургалт хийдэг байх.	
			2. Хүчин төгөлдөр удирдамж, зааврын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьдаг байх.	

4.		Тусламж, үйлчилгээ авахаар ирсэн тохиолдол бүрд бүртгэл хөтөлж, авсан арга хэмжээний талаар тэмдэглэл хөтөлдөг байх	1. Үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ хийх бүрд холбогдох хүчин төгөлдөр анхан шатны бүртгэлийн маягт, хяналтын хуудсыг хөтөлдөг, үзүүлсэн тусламж, үйлчилгээ, өгсөн зөвлөгөөний талаар тэмдэглэл хөтөлдөг байх.	
			2. Тусламж, үйлчилгээ үзүүлсэн бүртгэлтэй/ хяналтын карттай байх. Хэрэглэсэн эмчилгээний материал, тариа, эм хэрэгслийн бүртгэлтэй байх.	
			3. Мэс ажилбарын талаар мэдээлэл өгөх гарч болох хүндрэл эрсдэлийн талаар зөвшөөрөл авдаг байх.	
5.	Амь тэнссэн үеийн тусламжийн бэлэн байдлыг хангах, тусламж үйлчилгээг шуурхай үзүүлдэг байна.	Амилуулах тусламжийг үзүүлэх чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж, дадлагажуулдаг байх	1. Амилуулах тусламжийг багаар үзүүлэх сургалтад хамрагдсан, дадлага, сургуулилтыг хийдэг байх.	
			2. Яаралтай үед үйлчлүүлэгчийг биеийн байдал тогтворжуулан, аюулгүй байдлыг ханган тээвэрлэн шилжүүлдэг байх.	
6.		Яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангасан байна	1. Яаралтай тусламжийн нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалттай байх.	
			2. Эмийн хадгалалт, дуусах хугацааг хянадаг байх.	
7.	Эмийн аюулгүй байдлыг хангаж ажилладаг	Ижил дуудагддаг, ижил харагддаг эмчилгээний материал, тарианы хаягжилт болон хадгалалт нь бүх хэсэгт адил байх	1. Өндөр эрсдэлтэй, ижил дуудагддаг, ижил харагддаг эм, тариаг андуурахаас сэргийлэх, хаягжилт, хадгалалт, хэрэглээнд хяналт тавьдаг байх.	
8.		Эмийн жорыг стандартын дагуу бичдэг байх	1. Эмийн жор бичих стандартыг мөрддөг байх.	
			2. Үйлчлүүлэгчид жор бичиж өгдөг байх.	
9.	Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа явуулдаг байна.	Сургууль, цэцэрлэг, албан байгууллагад урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулдаг байх	1. Амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг хийн нийслэл аймгийн эрүүл мэндийн газарт тайлагнадаг байх. Нийгмийн хариуцлагын хүрээнд ажил зохион байгуулдаг байх.	
Онооны дүн		Авбал зохих оноо	...	

	Авсан оноо	...
--	-------------------	-----

НҮҮР АМНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

Огноо:

Эрүүл мэндийн байгууллагын нэр:

Хаяг:

Бүлгийн дугаар	Бүлгийн нэр	Шалгуур үзүүлэлтийн тоо	Авбал зохих оноо	Авсан оноо
Бүлэг 1	Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд			
Бүлэг 2	Байгууллагын үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд			
Бүлэг 3	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, технологийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд			
Нийт	Оноо			
	Хувь			

Үнэлсэн мэргэжилтэн /байгууллага/:

Хяналт тавьсан мэргэжилтэн /байгууллага/:

Танилцсан: